

ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

25
ЖИЛ

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

2019 · 8 сар | Дугаар 10

ГАРЧИГ

2–5 Ногоон санхүүжилт

7 Ховд аймагт “Санхүүгийн зах зээл” нээлттэй өдөрлөг боллоо

7 “Цаг агаарын өөрчлөлтийн эрсдэлийн даатгал” олон улсын зөвлөлдөх VII уулзалт болно

9–11 Байр суурь – Банк бус санхүүгийн салбарын өнөөгийн нөхцөл байдал болон СЗХ-оос хэрэгжүүлж буй бодлого, зохицуулалтын талаар мэдээлэл өгнө үү?

12–13 Финтек ба тогтвортой санхүүжилт

14–16 Судлаачын индэр – Үнэт цаасны зах зээл дэх ногоон санхүүжилт

16–17 Танилцуулга

18–20 Ярилцлага – Монгол Улсад тогтвортой санхүүжилт ямар шатанд байгаа вэ

20–21 Өргөн дуран – Хүртээмжтэй ногоон санхүүжилтийн 4р хүрээ

22–26 Зах зээлийн мэдээ /Хөрөнгийн зах зээл, Даатгалын зах зээл, Банк бус санхүүгийн байгууллага, Хадгаламж зээлийн хоршоо/

28 2019 онд болох үйл явдлууд

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫГ БИЕ ДААСАН, ТОГТВОРТОЙ, ЭРСДЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ ЧАДВАРТАЙ МЭРГЭЖЛИЙН САНХҮҮГИЙН ИНСТИТУЦ БОЛГОХ

Д.БОЛДМЯГМАР


БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗРЫН АХЛАХ ЗӨВЛӨХ

Та Банк бус санхүүгийн салбарын өнөөгийн нөхцөл байдал болон СЗХ-оос хэрэгжүүлж буй бодлого, зохицуулалтын талаар мэдээлэл өгнө үү?

2019 оны 2 дугаар улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд нийт 538 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаагаа явуулж байна. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасны дагуу банк бус санхүүгийн байгууллагууд нийт 10 төрлийн үйлчилгээг Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх боломжтой байдаг. Оны эхний улирлын байдлаар 492 банк бус санхүүгийн байгууллага буюу 91.4 хувь нь зээлийн үйл ажиллагаа, 155 банк бус санхүүгийн байгууллага буюу 8.6 хувь нь гадаад валют арилжааны үйлчилгээг дагнан эрхэлж байна. Салбарын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж буй банк бус санхүүгийн байгууллагуудын 86.1 хувь нь нийслэл Улаанбаатар хотод явуулж байгаа бөгөөд Монгол Улсын 21 аймагт нийт 75 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулж, орон нутгийн иргэдэд хүрч үйлчилж байна.

Банк бус санхүүгийн байгууллагуудыг бие даасан, тогтвортой, эрсдэлийг даван туулах чадвартай мэргэжлийн санхүүгийн институт болгох, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийн нэмэгдүүлэх, цаашлаад зээлийн хүүг бууруулах нөхцөлийг бий болгох зорилгоор тэдгээрийг чадавхжуулах бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.

ФИНТЕК БА ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ



Финтек нь гүйлгээний зардлыг бууруулж, капиталын үр ашигтай байдлыг нэмэгдүүлдэг.

Шинэ технологийн тусламжтайгаар гүйлгээний зардал болон хугацааг багасгаж, хөрөнгийн зарцуулалтыг хянах боломжтой болсноор үйл ажиллагааны үр ашигтай

байдал ерөнхийдөө нэмэгддэг. Газар тариаланд big data буюу том датаг ашиглан температур, чийг, хур тунадас зэрэг ургацын ургах орчинг хянах боломжтой болно. Цаашлаад энэ нь зээл, даатгал зэрэг санхүүгийн салбарт ашиглагдах боломжтой болдог.

Санхүүгийн зохицуулах хорооны

АЛСЫН ХАРАА

Чөлөөт, шударга өрсөлдөөнт, хэрэглэгчдийн эрх хамгаалагдсан, хүртээмжтэй, олон тулгуурт тогтвортой санхүүгийн зах зээлийг цогцлоож эдийн засгийн өсөлт, хөгжлийг тэтгэнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Санхүүгийн зохистой бодлого, үр ашигтай хяналт шалгалт, оновчтой зохицуулалтыг хэрэгжүүлж олон тулгуурт, хэрэглэгчдийн эрхийг хамгаалсан, итгэлийг нэмэгдүүлсэн тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.

ҮНЭТ ЗҮЙЛС

Цогц мөн чанар: Хүнлэг, үнэнч, шударга, итгэлтэй, өндөр ёс суртахуунтай байх нь;

Хариуцлагатай байх: Ажил үүргээ гүнээ ухамсарлаж, чин эрмэлзэлтэй, ажлын цагаа ажилдаа бүрэн зориулдаг, хичээнгүй нямбай, түргэн шуурхай, хувийн зохион байгуулалт сайн байх нь;

Мэргэжлийн байх: Өндөр мэдлэг, ур чадвар эзэмшсэн, өрсөлдөх чадвартай, ёс зүйтэй, зөв шийдэл гаргах чадвартай байх нь;

Бие даасан байх: Хувийн ашиг сонирхлоос ангид, хөндлөнгийн нөлөөгүй, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах нь;

Манлайлал, санаачлагатай байх: Шинийг эрэлхийлэгч, сайжруулан хөгжүүлэгч, манлайлагч, бүтээлч тэмүүлэлтэй байх нь;

Багаар ажиллах: Нэг зорилгын төлөө мэдлэг мэдээллээ хуваалцах, хамт олноо сонсох, итгэл хүндэтгэлтэй хандах, дэмжин туслах, жигд оролцоотойгоор үр өгөөжтэй хамтран ажиллах чадвартай байх нь

Бидний үнэт зүйлс юм.

Хүртээмжтэй санхүү

Санхүүгийн зохицуулах хороо товхимол

📍 Монгол Улс, Улаанбаатар хот 15160 Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3 Засгийн газрын IV байр.

☎ 976 51 261611

✉ press@frc.mn

🌐 www.frc.gov.mn

📍 Санхүүгийн зохицуулах хороо

📍 @FRC_of_Mongolia

Хэвлэл мэдээллийн алба

НОГООН САНХҮҮЖИЛТ



Б.БАТЧИМЭГ

СУДАЛГАА ЭРСДЭЛИЙН,
ШИНЖИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Бид яагаад ногоон санхүүжилтийн асуудлыг анхаарах ёстой вэ?

Санхүүгийн зах зээлийн бодлого гаргагчид, төв банк, зохицуулагч байгууллагуудын үндсэн зорилт нь үнийн тогтвортой байдал, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал, болон санхүүгийн байгууллагуудын тогтвортой, найдвартай үйл ажиллагааг ханган, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд чиглэдэг. Эдийн засаг, санхүүгийн зах зээлд тулгардаг бүтцийн өөрчлөлтийг ойлгох, таних, уг өөрчлөлтөөс үүдэх эрсдэлээс сэргийлэх, учирсан хохирлыг бууруулах чиглэлд ажиллах нь дээр дурдсан зорилтуудыг хангахад чухал нөлөөтэй билээ. Харин уур амьсгалын өөрчлөлт бол тэдгээр бүтцийн өөрчлөлтүүдийн нэг юм.

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх эрсдэл нь санхүүгийн зах зээл, макро эдийн засгийн тогтвортой байдалд системийн хэмжээг бүхэлд нь хамаарсан ихээхэн сөрөг нөлөөллийг үзүүлэх боломжтой юм. Дэлхий нийтэд тохиож буй байгалийн гамшиг, аюулт үзэгдлийн тоо, давтамж жил ирэх тусам улам бүр нэмэгдэж байгаа бөгөөд үүнээс үүдэх эдийн засаг, санхүүгийн алдагдлын хэмжээ ч мөн нэмэгдэж байна. Тухайлбал сүүлийн 10 жилд байгалийн гамшгаас үүдсэн эдийн засгийн хохирол 30 жилийн дунджаас давсан үзүүлэлттэй байна. Байгаль, цаг уурын гэнэтийн үзэгдэл нь хүний эрүүл мэнд, бүтээмжид сөргөөр нөлөөлж, хувийн баялаг, дэд бүтцийг сүйрүүлэн, үүнээс үүдэлтэйгээр эдийн засгийн үйл ажиллагаанд доголдол орж, илүү бүтээмжтэй ашиглагдаж болох байсан баялаг, хөрөнгүүд нөхөн сэргээх, засварлах үйл ажиллагаанд зарцуулагдаж, ирээдүйн талаарх хүлээлтээс үүдэн хөрөнгө оруулалтын хэмжээ буурч, гэнэтийн эрсдэлд ашиглах зорилготой хадгаламжийн хэмжээ нэмэгдэж байна. Мөн гэнэтийн байгалийн үзэгдлийн тоо, давтамж өсөхийн хэрээр даатгалын бүтээгдэхүүнүүдийн үнэ нэмэгдэж иргэд, аж ахуй нэгж болон даатгалын компаниуд аль алинд нь дарамт үзүүлж байна. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эдгээр эрсдэл нь эдийн засгийн төрөлжилт

Өдгөө дэлхий нийтэд тохиож буй уур амьсгалын өөрчлөлт хэрвээ уг өсөлтөө цаашид хадгалбал 21 дүгээр зууны сүүл үе гэхэд дэлхийн дундаж температур ойролцоогоор 3.7 цельс градусаар нэмэгдэж, далайн түвшин 63 см-ээр өснө гэсэн тооцоолол байдаг. Энэхүү дэлхийн дулаарлаас үүдэх эдийн засгийн хохирол нь ойролцоогоор дэлхийн нийт ДНБ-ий 20 орчим хүртэл хувьтай тэнцэх юм. Харин байгаль орчин, бидний амьдралын чанар, эрүүл мэнд цаашлаад хоол, хүнс, ундны ус зэрэг өдөр тутмын хэрэглээнд ямар хэмжээний хохирол үзүүлэхийг төсөөлөхөд бэрх.

Хүн төрөлхтний дунд сүүлийн үед хамгийн их яригдаж буй сэдэв бол тогтвортой хөгжил юм. Олон улс орны бодлого гаргагчид тогтвортой хөгжлийг нэн тэргүүний зорилтоо болгон “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”-ыг батлан хэрэгжүүлж байгаа билээ. Эдийн засаг, нийгмийн өсөлт хөгжилд хамгийн чухал хувь нэмэр оруулдаг санхүүгийн салбар ч мөн адил тогтвортой санхүүжилтийн нийтлэг зарчмыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр хичээнгүйлэн ажиллаж байна. Харин тогтвортой хөгжил, тогтвортой санхүүжилтийн нэг үндсэн зорилт нь байгаль орчинд ээлтэй эдийн засгийг бий болгох, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэж буй эрсдэлийг бууруулах, хүлэмжийн хийн ялгаралтыг багасгаж, нөхөн сэргээгдэх эрчим хүчийг өдөр тутмын хэрэгцээндээ ашиглахад чиглэсэн ногоон санхүүжилтийг зах зээлд нэвтрүүлэх болж байна. Албан ёсны тодорхойлолтоор бол ногоон санхүүжилт гэдэг нь санхүүгийн зах зээл, эдийн засгийн хөгжлийг дэмжих, байгаль орчны асуудлуудыг шийдэх, ахиц дэвшил гаргах гэсэн гурван чухал зорилтыг нэгэн зэрэг хангах санхүүжилтийг хэлнэ.

муутай, цаг уурын өөрчлөлтөд тэсвэр муу дэд бүтэцтэй, хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар нь сул, санхүүгийн зах зээлийн чадавх багатай улсуудад илүү өндөр зардалтайгаар тусаж байна.

Харин ногоон санхүүжилт нь байгаль орчинд сөрөг нөлөөгүй, тогтвортой бизнесийн төслүүдэд хөрөнгө оруулах, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэж буй эрсдэлийг бууруулах, түүнээс сэргийлэх шинэлэг санаа бүхий инновацийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, байгаль орчинд ээлтэй бизнес, төслийг санхүүжүүлэхэд чухал хувь нэмэртэй юм. Өөрөөр хэлбэл ногоон санхүүжилт нь санхүүгийн зах зээлээр дамжуулан байгаль орчноо хамгаалах, тогтвортой хөгжлийг бүрдүүлэх чухал гарц болж байгаа юм.

Ногоон санхүүжилт ба дэлхийн улс орнууд

Ногоон санхүүгийн болон хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний зах зээл Азийн санхүүгийн системд бага хувийг эзэлж буй хэдий ч эдгээр бүтээгдэхүүний зах зээлд нэвтрэх өсөлтийн хурд өндөр байгаагаар тогтохгүй ногоон санхүүжилтийн зарчимд нийцсэн олон инновацийн бүтээгдэхүүн уг зах зээлд аль хэдийн нэвтэрч эхлээд байна. Бодлого зохицуулалтын орчны хувьд ч мөн адил Азийн улс орнууд ногоон санхүүжилт, тогтвортой санхүүжилтийг дэмжсэн бодлого, зохицуулалтын орчныг бүрдүүлэн ажиллаж байна. Бангладеш, Энэтхэг, Индонез, Монгол, Вьетнам зэрэг улс орнууд ногоон санхүүжилтийн зарчмыг батлан хэрэгжүүлж эхлээд байгаа бол Лаос, Непал, Пакистан, Филиппин, Сингапур, Тайланд зэрэг улсууд уг зарчмыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Ногоон санхүүжилтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын хэрэгслүүд нь улс орон бүрийн эдийн засаг, нийгмийн хүчин зүйлсээс шалтгаалан өөр өөр байх хэдий ч бүхий л улс орнуудад ногоон санхүүжилтийн талаарх суурь ойлголтыг иргэд, аж ахуй нэгжүүдэд таниулах, байгаль орчноо хамгаалах, ирээдүйд бидэнд нүүрлэж болзошгүй эрсдэлийг сануулах, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтолтой аж ахуй нэгж, иргэн бүр тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх соёлыг суулгах нь нэн тэргүүний чухал асуудал болоод байна. Хэдийгээр зарим улс орнуудад зохицуулагч байгууллагууд нь ногоон санхүүжилтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөнгөлөлт, урамшууллыг зах зээлд оролцогчдодоо үзүүлэх, ногоон санхүүжилтийг амжилттай нэвтрүүлэх талаар заавар, зөвлөмж өгөх зэрэг байдлаар ажиллаж байгаа ч ногоон

санхүүжилтийг амжилттай нэвтрүүлсэн улс орнуудын туршлагаас харахад дүрэм, журам, зохицуулалтын шаардлагаар дамжуулан ногоон санхүүжилтийг санхүүгийн зах зээлдээ нэвтрүүлэх нь илүү үр дүнтэй байна.

Хууль, эрх зүйн орчин таатай, төрөөс гаргаж буй бодлого шийдвэр нь оновчтой, төрийн үйлчилгээ, тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаа нь хүнд суртал багатай, ойлгомжтой энгийн байх зэрэг бодит эдийн засаг, нийгэмд тулгардаг асуудлууд нь өөрөө ногоон санхүүжилтийн өсөлт, хөгжилд чухал нөлөө үзүүлдэг. Учир нь хөрөнгө оруулалтын орчин нөхцөл таатай бус зах зээлд ногоон санхүүжилт, ногоон хөрөнгө оруулалтын төслүүдийг ярих улам ч хүндрэлтэй болох юм. Эсрэгээрээ ил тод, урт хугацааны оновчтой бодлоготой улс орнуудад хөрөнгө оруулалт их хийгдэж, шинэ үйлдвэрүүд баригдан технологийн дэвшил хурдацтай нэвтрэн, ажлын байр ихээр бий болохын зэрэгцээ хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах, байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалах үйл ажиллагаанууд илүү сайн хийгдэж, эдгээр үйл ажиллагаанд зориулсан хөрөнгө оруулалт ч их хийгддэг байна. Өөрөөр хэлбэл ногоон санхүүжилтийг нэвтрүүлэх асуудал нь

өөрөө тухайн улсын эдийн засаг, санхүүгийн зах зээлийн хөгжлөөс ихээхэн хамаардаг юм.

Тийм ч учраас манай улс оронтой адил олон хөгжиж буй орнуудад ногоон санхүүжилтийг амжилттай нэвтрүүлэхэд хөрөнгө оруулалтын дутмаг байдал, санхүүгийн зах зээлийн сул хөгжил хамгийн том бэрхшээл болж байна. Хөгжиж буй улс орнуудын санхүүгийн зах зээлд өндөр хөгжилтэй улсуудтай харьцуулахад харьцангуй жижиг, төвлөрөл ихтэй, банкны салбар давамгайлсан бүтэцтэй байдаг. Статистик мэдээллээс харахад хөгжиж буй улсуудын санхүүгийн зах зээлийн нийт хөрөнгийн 85–90 орчим хувийг нь банкны салбар дангаар бүрдүүлдэг байна. Тийм учраас хөгжиж буй улс орнууд ногоон санхүүжилт, тогтвортой санхүүжилтийг нэвтрүүлэхдээ банкны салбараасаа эхлэн хэрэгжүүлдэг байна. 2012 онд Олон улсын тогтвортой санхүүжилтийн холбоо (OУТoСХ/ SBN) байгуулагдсан бөгөөд уг сүлжээнд өдгөө дэлхийн 20 гаруй улсын зохицуулагч байгууллагууд гишүүнчлэгддэг. Эдгээр гишүүн улсууд тогтвортой санхүүжилтийн үндэсний бодлого, замын зургийг боловсруулан тогтвортой банкны зарчим, заавар зөвлөмжийг батлан хэрэгжүүлж байна.

Хүснэгт 1. Хөгжиж буй улс орнуудын баримталж буй тогтвортой банкны бодлого

Улс	Бодлого	Боловсруулсан байгууллага	Огноо	Сайн дурын эсэх
Бангладеш	Байгаль орчны Эрсдэлийн Менежментийн Удирдамж	Бангладешийн Төв Банк	2011	Албан журмаар
Колумб	Ногоон Протокол	Колумбын Банкны Холбоо	2012	Сайн дураар
Монгол	Монголын Тогтвортой Санхүүжилтийн Зарчмууд	Монголын Банкны Холбоо	2015	Сайн дураар
Нигер	Нигерийн Тогтвортой Банкны Зарчмууд	Нигерийн Төв Банк	2014	Албан журмаар
Вьетнам	Байгаль орчны болон Эрсдэлийн Менежмент	Вьетнамын Төв Банк	2014	Албан журмаар
Перу	Нийгмийн болон Байгаль орчны Эрсдэлийн Менежмент дэх зохицуулалт	Банк, Даатгал, Хувийн тэтгэврийн сангийн удирдлагууд	2015	Албан журмаар

Өнөөгийн байдлаар банкны салбарт хамгийн түгээмэл нийлүүлэгдэж буй ногоон бүтээгдэхүүнд эрчим хүчний хэмнэлттэй орон сууцанд хөнгөлөлттэй нөхцөлөөр олгож буй ногоон ипотекийн зээл, болон орон сууц, барилга байгууламждаа эрчим хүчний хэмнэлттэй, хог хаягдлыг дахин боловсруулах, бууруулах зориулалтаар шинэчлэлт хийх, засвар оруулахад зориулсан төрөл бүрийн ногоон барилгын зээл, автомашины ногоон зээл, мөн худалдан авалт, гүйлгээний шимтгэл бүрийн тодорхой хувийг ногоон төслүүдэд хандивлах зориулалттай ногоон картын үйлчилгээ зэрэг багтаж байна.

Даатгалын салбарын хувьд мөн адил зах зээлд эзлэх хувь хэмжээ нь бага байгаа хэдий ч сүүлийн үед хурдтай өсөж байна. Хөдөө аж ахуйн даатгал, гэнэтийн эрсдэл, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх даатгалын бүтээгдэхүүнүүд олноор гаран өндөр эрэлттэй байгаа хэдий ч бага орлоготой өрхүүдэд зориулсан бичил даатгалын бүтээгдэхүүн цөөн байгаа нь хөгжиж буй орнуудын хувьд нийтлэг ажиглагдаж байна. Дэлхийн хэмжээнд байгаа нийт бичил даатгалын үйлчилгээг хэрэглэгчдийн 85 хувь нь Ази, 10 хувь нь Латин Америк, 5 хувь нь Африкийн зах зээлд байна. Филиппин улсад уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх эрсдэлээс

хамгаалах зорилготой бичил даатгалын үйлчилгээ нэвтэрсэн бөгөөд уг даатгалыг сүм хийд, мэргэжлийн холбоод зэрэг нийгмийн бүлгүүд эрсдэлээ тархаах зорилгоор хамтран ашиглаж байна. Энэхүү даатгалын үйлчилгээ нь байгалийн гамшигт нэрвэгдэх хамгийн их магадлалтай, гамшигт үзэгдлээс хамгийн их хохирол амсаж болзошгүй бага орлоготой, эмзэг бүлгийн хүмүүст чиглэн хэрэгжиж байгаа нь ногоон даатгалын бүтээгдэхүүний амжилттай жишээ юм.

Мөн ихэнх хөгжиж буй улс орнуудын хувьд хөрөнгийн зах зээл тэр дундаа бондын зах зээлийн идэвхжил муу байдаг нь ногоон хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэхийн тулд нэн тэргүүнд зах зээлээ тэлэх, төвлөрлийг бууруулах, хөрвөх чадварыг сайжруулах, институционал хөрөнгө оруулагчдыг нэмэгдүүлэх, дэд бүтэц, засаглалаа сайжруулах зэрэг зах зээлийн хөгжлийн томоохон асуудлуудыг шийдэх шаардлагыг бий болгож байна. Хөрөнгийн зах зээлд амжилттай нийлүүлэгдэж буй ногоон санхүүгийн бүтээгдэхүүн бол ногоон бонд юм. 2008 онд Дэлхийн банк анхны ногоон бондыг гаргаж байсан бол 2018 оны байдлаар ногоон бондын нийт 91 төсөл 28 улсыг хамран хэрэгжиж 15.4 тэрбум ам.долларын санхүүжилтийг босгожээ. Эдгээр төслүүдийн 44 хувь нь сэргээгдэх эрчим хүч ашиглах, эрчим хүчний хэмнэлтийг сайжруулахад, 25 хувь нь байгальд ээлтэй тээврийн үйлчилгээнд, 11 хувь нь хөдөө аж ахуй, газар ашиглалт, экологийн нөөц зарцуулалтад чиглэсэн төслүүд байна.

Түүнчлэн уур амьсгалын сан, цаг агаарын дервативын бүтээгдэхүүн, дижитал ногоон санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ зэрэг олон төрлийн ногоон санхүүгийн бүтээгдэхүүн олон улсын зах зээлд шинээр нэвтэрч байна. Мөн ногоон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор ногоон бизнесийн индекс, ногоон эрсдэлийн индекс, тухайн бизнесийн үйл ажиллагаанд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх эрсдэл хэр байгааг тодорхойлох зорилготой карбон индекс зэрэг индексүүд санхүүгийн зах зээлд ашиглагдаж байна.

Ногоон санхүүжилт ба Монгол Улс

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Үзэл Баримтлал 2030” батлагдсан. Энэхүү үзэл баримтлалаар Монгол Улс 2030 онд нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой өсөж

байгаа эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхарга давамгайлсан, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, тогтвортой ардчилсан засаглалтай улс болох зорилгыг тавьсан байдаг.

Үзэл баримтлалд эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих хөгжлийн санхүүжилтийн болон санхүүгийн зах зээлийн зохистой тогтолцоог хөгжүүлэх, санхүүгийн зах зээлд банкнаас бусад санхүүгийн байгууллагын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, арилжааны банк, хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээлийн эзлэх хувийг зохистой түвшинд хүргэх зорилт тусгагдсан байдаг бол Монгол Улсыг ногоон эдийн засгаар тэргүүлэгч улсын тоонд оруулах зорилтыг мөн тусгасан байдаг.

Энэхүү баримт бичиг, нийгэм, эдийн засгийн бодлого зорилтуудыг бодитойгоор хэрэгжүүлэх, байгаль орчинд ээлтэй ногоон эдийн засгийн хөгжлийн загварлуу шилжихэд тогтвортой санхүүжилт, ногоон санхүүжилтийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага урган гарч ирсэн.

2017 оны 10 дугаар сард Засгийн Газрын 299 дүгээр тогтоолоор “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” батлагдсан бөгөөд уг хөтөлбөрт санхүүгийн салбарт тогтвортой санхүүжилтийн зарчмыг цогцоор нь нэвтрүүлэх бодлогын зорилтыг тусгаж, тогтвортой санхүүжилтийн үндэсний стратегийг хэрэгжүүлэх, хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудад байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын тайлагналын зарчим, шаардлагыг боловсруулж, нэвтрүүлэх, тогтвортой санхүүжилтийн чадавх бий болгох зорилгоор олон нийтэд мэдлэг түгээх зэрэг үйл ажиллагаануудыг тусгасан.

Мөн уг хөтөлбөрт хөрөнгийн зах зээлд ногоон бонд гаргах зарчим, шаардлагыг тодорхойлон, ногоон бондыг дэмжих урамшууллын механизм бий болгох, байгаль орчин, нийгэмд ээлтэй, ногоон төслүүдийн санхүүжилтийг нэвтрүүлэх, ногоон зээлийн санг үүсгэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх, ногоон санхүүжилтийн урсгалыг нэмэгдүүлэн ногоон эдийн засгийн засгийн өсөлтийг дэмжих, шинэ ажиллах хүчин болох их дээд сургуулийн оюутан залуучуудад ногоон эдийн засгийн мэдлэг олгох сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэг ажлуудыг тусган Санхүүгийн зохицуулах хороо, МонголБанк, Сангийн Яам болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран

ажиллаж байна.

2018 оны 9 дүгээр сард Санхүүгийн зохицуулах хороо “Санхүүгийн зохицуулах хорооны стратеги, төлөвлөгөө (2018–2021 он)”-г батлан хэрэгжүүлж байгаа ба уг стратегийн анхаарал хандуулж буй онцлох чиглэл нь ногоон эдийн засгийг дэмжсэн байгаль орчинд болоод нийгэмд ээлтэй тогтвортой санхүүжилт юм.

Харин Монгол Улсын санхүүгийн салбарын 95 хувийг бүрдүүлж буй банкны салбарын хувьд тогтвортой хөгжлийг дэмжсэн, байгаль орчин, нийгэмд ээлтэй ногоон төсөл, хөтөлбөрүүдэд санхүүжилт олгох, зээл хүсэгч ААН, иргэдэд байгаль орчинд ээлтэйгээр үйл ажиллагаа явуулах шаардлага тавих зэрэг нь ногоон санхүүжилт манай улсын зах зээлд нэвтрэхэд чухал ач холбогдолтой юм. Иймд төрийн байгууллагууд, арилжааны банкууд болон хувийн хэвшлийн төлөөллүүд хэлэлцэн Монгол Улсын Тогтвортой Санхүүжилт (ТоС)-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Уг хөтөлбөр нь санхүүгийн зохицуулагч байгууллагууд болон зах зээлд оролцогчид, харилцагчдын дунд тогтвортой санхүүжилтийн мэдлэг ойлголтыг гүнзгийрүүлэх, чадвар чадамжийг бий болгоход чиглэсэн. ТоС хөтөлбөрийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголын банкны холбоо, арилжааны банкуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг боловсруулж ТоС-ийн зарчмууд болон уул уурхай, барилга, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэр гэсэн 4 салбарын удирдамжийг Олон Улсын Санхүүгийн Корпораци, Нидерландын Хөгжлийн банкны зөвлөхүүдийн тусламжтайгаар боловсруулан 2015 оны 1 дүгээр сараас эхлэн ТоС-ийн зарчмуудыг банкууд үйл ажиллагаандаа хэрэгжүүлж эхлэв. Энэхүү зарчмууд нь байгаль орчин, хүний эрх, соёлын өв, ногоон эдийн засаг, санхүүгийн хүртээмж, ил тод байдал зэрэг бидний тулгамдаж буй чухал асуудлуудыг тусгасан ба банкнаас санхүүжүүлж буй төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийг тодорхойлж, бууруулах, цаашлаад ногоон төслүүдийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд банкуудад дэмжлэг, чиглэл өгөх зорилготой юм.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй бүх банкууд ТоС-ийн зарчмуудыг хэрэгжүүлж, өөрсдийн үйл ажиллагаандаа байгаль орчин, нийгмийн удирдлагын системийг бүрдүүлэн, зээл санхүүжилт олгохдоо байгаль орчин, нийгмийн эрсдэлийг тооцоолон ажиллаж

байна. Мөн уул уурхай, барилга, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэр зэрэг байгаль орчин, нийгмийн өндөр эрсдэлтэй салбаруудад чиглэсэн тусгай шаардлагуудыг тавин ажиллаж байгаа ба ингэхдээ тухайн бизнесээ аль болох дэмжих, зөвлөгөө өгөх, сөрөг нөлөөллийг бууруулах арга замыг эрэлхийлэн хамтран ажиллаж байна.

Түүнчлэн 2018 оны 12 дугаар сард Монгол Улсын Тогтвортой Санхүүжилтийн Үндэсний замын зургийг “Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ”, “Ногоон зээл”, “Тогтвортой санхүүжилтийг дэмжих хамтын ажиллагаа, бодлогын орчин” гэсэн 3 ерөнхий бүлэгтэйгээр боловсруулан батлаад байна. Энэхүү замын зурагт тусгагдсан үйл ажиллагааг бодлого, зохицуулалтын талаас нь Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголын Хөрөнгийн Бирж, Үндэсний хөгжлийн газар голлон хэрэгжүүлэх юм.

Ногоон санхүүжилтийг нэвтрүүлэхэд бид юуг анхаарах хэрэгтэй вэ?

Ерөнхийдөө уур амьсгал, байгаль орчны доройтол, гэнэтийн аюул, эрсдэлт байдал нь нэг төслийн хэрэгжилт, нэг хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчээс эхлээд эдийн засаг, санхүүгийн салбар цаашлаад улс орон, дэлхийн хэмжээнд чухал нөлөө үзүүлдэг, их хэмжээний эрсдэлийг дагуулдаг талаарх олон нийтийн мэдээлэл дутмаг байгаа нь тогтвортой санхүүжилтийн үйл ажиллагаа, хөгжил дэвшилд сөргөөр нөлөөлж байна. Мөн байгаль орчин, уур амьсгалын эрсдэлийг тодорхойлох, үнэлэх чадвартай бэлтгэгдсэн мэргэжлийн боловсон хүчин санхүүгийн салбарт дутагдаж байгаа нь бас нэгэн бэрхшээл болж байна. Боловсон хүчний энэхүү дутмаг байдлаас шалтгаалан ногоон санхүүжилтийн үйлчилгээ үзүүлэх санхүүгийн байгууллагын урсгал зардал нэмэгдэж энэ төрлийн үйлчилгээг эрхлэх сонирхол буурдаг байна.

Санхүүгийн зах зээлд ногоон санхүүжилтийг амжилттай нэвтрүүлэхийн тулд санхүүгийн байгууллагууд, зохицуулагч байгууллагууд нэн тэргүүнд засаглалын дараах зорилтуудыг биелүүлэх хэрэгтэй. Үүнд:

- Санхүүгийн зах зээлд оролцогч байгууллагууд, зохицуулагч байгууллагуудад байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх эрсдэлийг таниулах;
- Мэдлэг түгээх, мэдлэг хуваалцах

замаар санхүүгийн салбар дахь байгаль орчны эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн менежментийн чадавхыг сайжруулах;

- Нөхөн сэргээгдэх эрчим хүч зэрэг тогтвортой санхүүжилтийн төслүүдэд зориулсан зээлийн шинэ бүтээгдэхүүн, санхүүжилт, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнийг санхүүгийн зах зээлд нэвтрүүлэх шаардлагатай ба үүний тулд зах зээлийн чадавхыг нэмэгдүүлэх;
- Байгаль орчин, нийгэм, засаглалын тайлагналаар дамжуулан ил тод байдлыг нэмэгдүүлэх;
- Ногоон төслийг санхүүжүүлэх сэдлийг банк болон банк бус санхүүгийн байгууллагуудад өгөх;
- Ногоон бондын зах зээл, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх эрсдэлийг бууруулах даатгалын бүтээгдэхүүн зэрэг шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх замаар зах зээлд шинэ сегмент үүсгэх, үүнийг бодлогоор дэмжих;

Түүнчлэн санхүүгийн зах зээлд орох хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлэхэд бодлогоор дэмжих, зарим төрлийн бүтээгдэхүүн, санхүүжилтийн үйлчилгээг татвар болон зохицуулалтын шаардлагуудаас хөнгөлөх, байгаль орчинд сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулж буй байгууллагын санхүүгийн тайлан мэдээнд үндэслэн агаарын бохирдлын төлбөр, болон бусад шаардлагатай төлбөрүүдийг төлж буй эсэхэд хяналт тавих, мөн хүлэмжийн хийн ялгаруулалт, байгаль орчинд сөрөг нөлөөтэй явуулж буй үйл ажиллагааг ил тод болгох зэрэг зохицуулалтын арга хэрэгслээр ногоон санхүүжилтийг нэмэгдүүлэх, дэлгэрүүлэх боломжтой юм.

Ногоон хөрөнгө оруулалтын төслүүд нь бусад төслүүдтэй харьцуулахад ихэвчлэн эргэн төлөгдөх хугацаа багатай, биет ашиг багатай байдаг учраас хувийн хөрөнгө оруулагчид уг зах зээлд нэвтрэх сонирхол ногоон эдийн засаг, санхүүгийн ойлголт хөгжөөгүй зах зээлийн хувьд бага байдаг. Тиймээс төрөөс байгаль орчинд ээлтэй технологийн шийдлүүд, ногоон үйл ажиллагаа эрхэлж буй жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилго бүхий ногоон хөрөнгө оруулалтын корпораци, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг ногоон сан, ногоон зээлийн батлан даалтын сан зэргийг байгуулан зах зээлийг хөгжлийг дэмжих боломжтой юм.

Дүгнэлт

Байгаль орчны бохирдол, нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн хомсдол, дэлхийн дулаарал үүнээс үүдэх гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс, халдварт өвчлөл зэрэг нь баян, ядуу, эрэгтэй, эмэгтэй гээд нийгмийн бүхий л бүлгийн хувьд тулгарч буй хамгийн том асуудал бол бас аюул болоод байна. Нэг иргэн, нэг аж ахуй нэгж гэлтгүй та бидний хариуцлагагүй үйлдлээс шалтгаалан олон зуун амьтад устаж, олон зуун хүн гэр бүл, орон байраа алдах асуудлууд сүүлийн жилүүдэд улам их тохиож байгаа билээ. Үүнээс улбаалан улс орнуудын бодлого гаргагчид, иргэний нийгмийн байгууллагууд, сайн дурын холбоод, оюутан залуус гээд нийгмийн бүхий л шатны төлөөлөл ямарваа нэгэн байдлаар байгаль орчны асуудлаар үзэл бодлоо илэрхийлэн, байгаль орчноо хамгаалах хөдөлгөөнүүдийг эхлүүлээд байна.

Харин улс орны эдийн засаг, нийгмийн хөгжил, ард иргэдийн амьдралын чанарт шууд нөлөө үзүүлдэг санхүүгийн салбар байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд чухал байр суурьтай юм. Учир нь санхүүгийн салбар, санхүүгийн байгууллагын оролцоогүй, нийгэм, эдийн засаг, өрхийн амьдрал гэж байдаггүй билээ.

Байгаль орчны өөрчлөлтөөс үүдэх эрсдэлт хүчин зүйлс, байгалийн нөөц баялгийн доройтол улам бүх нэмэгдэж, дэлхий нийтэд аж ахуй нэгж, байгууллагуудын менежмент тогтвортой хөгжлийн парадигмуу шилжиж буй жишээ ихэсч, олон улсын байгууллагууд, хөрөнгө оруулагчид байгаль орчны асуудлыг ихэд анхааран ногоон үйл ажиллагааг шаардах болсон энэ үед манай улсын санхүүгийн зах зээл мөн тэдний хөгжилтэй эн зэрэгцэн хурдтай алхаж, ногоон санхүүжилтийг амжилттай нэвтрүүлснээр ирээдүйд хүлээгдэж буй гэнэтийн эрсдэлийг бууруулах, эрүүл таатай орчинд ажиллаж, амьдрах, хойч үедээ үзэсгэлэнт байгаль нутгаа өвлүүлэн үлдээх, эх дэлхий, дээр нь амьдарч буй амьд бүхнийг аюулаас хамгаалахад хувь нэмрээ оруулах, олон улсад жишиг тогтоон ногоон эдийн засгаар тэргүүлэх орон болох, бүс нутаг, олон улсын түвшинд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх, гадны хөрөнгө оруулалтыг татах замаар эдийн засгаа солонгоруулах зэрэг олон давуу талтай юм. Харин энэхүү үйл хэргийг хэрэгжүүлэхэд санхүүгийн зах зээлийн зохицуулагч байгууллагууд, мэргэжлийн холбоод, санхүүгийн байгууллагууд, болон санхүүгийн үйл ажиллагаанд өдөр тутам оролцож буй иргэн, аж ахуй нэгж бүрийн хүчин чармайлт нэн чухал билээ.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

“УИД” ХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооноос “УИД” ХК-ийн 2016–2018 оны үйл ажиллагаанд Хорооны даргын баталсан удирдамжийн дагуу 2019 оны 3 дугаар сараас 5 дугаар сарын хооронд газар дээрх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Хороо нь “УИД” ХК-тай 2017 онд “УИД ХК-ийн үйл ажиллагааг сайжруулах, бие даасан байдлыг хангуулах гэрээ”-г байгуулж тус гэрээнд “УИД ХК-ийн барилгыг түрээслэх гэрээний үнийн дүнг тухайн үеийн зах зээлийн ханштай дүйцүүлэх...” гэж заасан. Гэвч “УИД” ХК нь “Номин реалтор” ХХК-тай түрээсийн гэрээг зах зээлийн үнээс хэт бага үнээр хийж дээрх гэрээнд заасан үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Үүний улмаас “УИД” ХК нь 2016 онд 3.9 тэрбум, 2017 онд 2.4 тэрбум, 2018 онд 2.6 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллах, нэгж хувьцаанд 2016 онд 106 төгрөг, 2017 онд 65 төгрөг, 2018 онд 71 төгрөгийг ногдол ашиг хэлбэрээр хуваарилах боломжийг тус тус алдсан байна гэж шалгалтын ажлын хэсгээс дүгнэлээ.

Түүнчлэн “УИД” ХК нь “Номин холдинг” ХХК-тай зээлийн гэрээг гадаад валютаар байгуулж, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийг зөрчсөн тул Санхүүгийн зохицуулах хорооноос Улсын ерөнхий прокурорын газарт хандан зөрчлийн хэрэг нээж, хэрэг бүртгэлийн ажиллагааг эхлүүлээд байна.

Мөн шалгалтын ажлын хэсгээс “УИД” ХК-ийн холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн бусад үйл ажиллагаанд торгууль оногдуулж, улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр холбогдох хууль тогтоомжид заасны дагуу арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажиллахаар боллоо.

ХОРООНЫ 2019 ОНЫ ЭЭЛЖИТ XI ХУРАЛДААН БОЛЖ НИЙТ 30 АСУУДЛЫГ ХЭЛЭЛЦЭЖ ШИЙДВЭРЛЭЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны ээлжит XI хуралдаан 7 дугаар сарын 8-ны өдөр болж нийт 30 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Хуралдаанаар “Мөнх даатгал” ХХК-ийн

8 салбарыг, “Хас-Үнэлгээ” ХХК-ийн төлөөлөгчийн газрыг бүртгэж, нэр бүхий 22 иргэнд даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 6 иргэний тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, “Тэнгэр даатгал” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтныг томилохыг зөвшөөрөв.

Мөн “Трасс Чэйн менежемент” ХХК-д хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, “Домикс сек” ХХК-д үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, “МИК актив хорь” ХХК-д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олголоо.

“МИК актив хорь” ХХК-ийн гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг, “Үндэсний хувьчлалын сан” хаалттай, хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэн авч, “Блэкстоун интернэйшнл ҮЦК” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах, “Санар ҮЦК” ХХК-ийн гүйцэтгэх захирлыг томилохыг зөвшөөрөв.

Хуралдаанаар “Хавцалын боом” хоршоонд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх

тусгай зөвшөөрөл олгож, “Ноён даамал”, “Монсант алдар”, “БЭХ”, “Кредит-Юнион монгол”, “Мина” ХЗХ-дын хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгалаа.

“Эрин финанс” ХХК-д банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, “Би энд Жи финанс ББСБ” ХХК-д банк бус санхүүгийн факторингийн үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгохыг зөвшөөрөв.

Харин “Таван ханхар”, “Хужиртайн булгийн ундарга”, “Субуд”, “Өнөр их наяд” ХЗХ-дын хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болголоо.

“Би эй ди эй би ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээж, “Прайм финаншл холдингс ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, “Улам хөгжих ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгов.

Мөн салбарын үйл ажиллагаатай холбоотой зарим журмыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн дахин хэлэлцэн баталлаа.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА С.ДАВААСҮРЭН ГОВЬ-АЛТАЙ АЙМАГТ АЖИЛЛАВ

Санхүүгийн зохицуулах хороо, Говь-Алтай аймгийн засаг даргын тамгын газартай хамтран “Санхүүгийн зах зээл” нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж ажиллав. Өдөрлөгт орон нутагт үйл ажиллагаа явуулж буй банк бус санхүүгийн байгууллага, даатгалын компани, хадгаламж зээлийн хоршоо, үнэт цаасны компаниуд болон арилжааны банкууд оролцож бүтээгдэхүүн, үйлчилгээгээ олон нийтэд танилцууллаа.

Мөн орон нутагт санхүүгийн зах зээлийн талаар мэдээлэл өгөх, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор даатгал, үнэт цаасны зах зээл болон мөнгө угаах, терроризмтэй тэмцэх, комплаенсын чиглэлээр сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулав. Арга хэмжээнд орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагууд, үнэт цаас, ББСБ, ХЗХ, Даатгалын байгууллагууд болон иргэд оролцлоо.

Тус аймагт Санхүүгийн зохицуулах хорооны дарга, доктор С.Даваасүрэн тэргүүтэй ажлын хэсэг ажиллав.




ХОВД АЙМАГТ “САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ” НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ БОЛЛОО

2019 оны 7 дугаар сарын 31-ний өдөр Ховд аймагт “Санхүүгийн зах зээл” нээлттэй өдөрлөг болж орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагууд, банк, үнэт цаас, ББСБ, ХЗХ, Даатгалын байгууллагууд болон иргэд оролцлоо. Өдөрлөгийг Санхүүгийн зохицуулах хороо, Ховд аймгийн засаг даргын тамгын газартай хамтран зохион байгуулав.

Энэ үеэр орон нутагт санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлагын талаар мэдээлэл өгөх, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор даатгал, үнэт цаасны зах зээл болон мөнгө угаах, терроризмтэй тэмцэх, комплаенсын чиглэлээр ээлжит сургалт, хэлэлцүүлгийг хийв. Хорооноос тус сургалтыг зүүн бүс, говийн бүс, хангайн бүс, төвийн бүс, баруун бүс гэсэн чиглэлээр зохион явуулаад байна.

Ховд аймагт Санхүүгийн зохицуулах хорооны дарга, доктор С.Даваасүрэн тэргүүтэй ажлын хэсэг ажиллав.



“ЦАГ АГААРЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЭРСДЭЛИЙН ДААТГАЛ” ОЛОН УЛСЫН ЗӨВЛӨЛДӨХ VII УУЛЗАЛТ БОЛНО

Санхүүгийн зохицуулах хороо, ХБНГУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ) болон “Азийн орнуудад хүртээмжтэй даатгалын зах зээлийг хөгжүүлэхэд зохицуулалтын байгууллагын оролцоо” хөтөлбөр (MEFIN, The Mutual Exchange Forum on Inclusive Insurance)-тэй хамтран Төр, хувийн хэвшлийн олон улсын зөвлөлдөх ээлжит VII уулзалтыг Улаанбаатар хотноо 2019 оны 9 дүгээр сарын 17-18-ний өдрүүдэд зохион байгуулна.

Зөвлөлдөх уулзалт нь цаг уур, гамшгийн эрсдэлийн даатгал (CRI)-ын эрх зүйн орчин ба зохицуулалт, түүний бизнес загвар, технологид суурилсан даатгалын салбар, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сэдвийн хүрээнд явагдана.

Мөн энэ үеэр “Азийн орнуудад хүртээмжтэй даатгалын зах зээлийг хөгжүүлэхэд зохицуулалтын байгууллагын оролцоо” хөтөлбөр (MEFIN)-ийн хуралдаан болох бөгөөд, хуралдааныг Санхүүгийн зохицуулах хорооны дарга, доктор С.Даваасүрэн удирдаж явуулах юм.

“Цаг агаарын өөрчлөлтийн эрсдэлийн даатгал” Олон Улсын зөвлөлдөх VII уулзалтад оролцох хүсэлтэй иргэд, байгууллагууд СЗХ-ны Даатгалын газрын daatgal@frc.mn хаягаар бүртгүүлж хамрагдах боломжтой.



ОЛОН УЛСЫН ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ЗОХИЦУУЛАГЧДЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ БОЛЛОО

Олон улсын хадгаламж, зээлийн хоршооны зохицуулагчдын зөвлөл (ICURN)-ийн жилийн хурал АНУ-ын Чикаго хотноо долоодугаар сарын 24-26-ны өдрүүдэд боллоо.



“ХЯНАН ШАЛГАГЧИД ЗОРИУЛСАН МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ГАРЫН АВЛАГА”-ЫГ БАТАЛЛАА

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) чиглэлээр бодлого боловсруулах, улс орнуудад зөвлөмж өгөх чиг үүрэг бүхий байгууллага болох Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага

ICURN нь гишүүдийнхээ хэрэгцээнд нийцсэн үйл ажиллагаа явуулахыг зорьж байгаа харьцангуй шинэ байгууллага бөгөөд 6 тивийн 39 улс гишүүн нь юм. Тус зөвлөлд 2019 онд Уганда, Өмнөд африк, Барбадос, Мьянмарын зохицуулалтын байгууллагууд шинээр элсжээ. Монгол Улсын банкнаас бусад санхүүгийн зах зээлийн зохицуулалтын байгууллага СЗХ нь 2017 онд гишүүнээр элсэж, хамтран ажиллаж байна.

Олон улсын хадгаламж, зээлийн хоршооны зохицуулагчдын зөвлөл (ICURN) нь 2015 оноос эхлэн гишүүн байгууллагуудаа оролцуулсан жилийн хурлыг зохион байгуулж байна. Хурлын үеэр зохицуулагчид нэг дор цугларч хяналт шалгалтын сүүлийн үеийн чиг хандлага, арга хэлбэрийн талаар хэлэлцдэг. Энэ удаагийн хуралд 18 орны 61 төлөөлөгч оролцлоо.

Хуралд оролцогчид дугуй ширээний уулзалт хийж, өөр өөрийн орны хадгаламж, зээлийн хоршооны зах зээл, тулгамдсан асуудлыг ярьж, шийдвэрлэх арга замын талаар харилцан санал солилцож, кибер аюулгүй байдал, ФинТек-РэгТек-СупТек/зохицуулалт, хяналт шалгалтын зардал, хадгаламжийн даатгалын тогтолцоо, залилах гэмт хэргийг илрүүлэхэд технологийг ашиглах боломж, хадгаламж, зээлийн хоршоог өөрчлөн байгуулах зэрэг сэдвээр хэлэлцүүлэг өрнүүллээ.

(ФАТФ)-аас гаргадаг 40 зөвлөмжийн 26-д заасны дагуу мэдээлэх үүрэгтэй этгээд нь МУТСТ-д тавигддаг шаардлагуудыг хэрхэн биелүүлж байгааг хянаж шалгах, зохицуулахад чиглэгдсэн арга хэмжээг авч ажиллах ёстой.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 327 дугаар тогтоолоор баталсан “Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын

төлөвлөгөө”-нд “Санхүүгийн зохицуулах хороо салбарын эрсдэлийн үнэлгээг зайнаас хийж, холбогдох хяналт шалгалт хийх заавар, журам, гарын авлагыг боловсруулна” гэж заасан байдаг. Үүнтэй холбоотой Хорооноос 2018 оны 239 дүгээр тогтоолоор “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”, журмыг дагалдуулж холбогдох тайлан мэдээлэх заавар, өгөгдөл цуглуулах маягт, үнэлэх асуулга, эрсдэлийн үнэлгээний матриц зэрэг баримт бичгүүдийг баталсан.

Хорооноос мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд мөнгө угаах болон терроризмтой тэмцэх чиглэлээр зайнаас болон газар дээрх хяналт шалгалтыг тогтмол явуулж ирсэн хэдий ч хянан шалгагчид нь газар дээрх хяналт шалгалтыг явуулахад зориулсан нарийвчилсан гарын авлага батлагдаагүй. Газар дээрх хяналт шалгалтыг илүү цогц, чамбай болгох зорилгоор Хорооны хянан шалгагч нарт зориулан “МУТСТ чиглэлээр газар дээрх хяналт шалгалт хийх” гарын авлагыг баталлаа.

“ЦАХИМ ТӨЛБӨР ТООЦОО, МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН ҮЙЛЧИЛГЭЭ, ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛГҮЙ ЭРХЭЛЖ БҮЙ ЭТГЭЭДИЙГ ОЛЖ ТОГТООХ, ХЯНАЛТ ТАВИХ, МЭДЭЭЛЭХ ЗААВАР”-ЫГ БАТЛАВ

Санхүүгийн зохицуулах хорооноос Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) чиглэлээр бодлого боловсруулах, улс орнуудад зөвлөмж өгөх чиг үүрэг бүхий байгууллага болох Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага (ФАТФ)-аас гаргасан 40 зөвлөмжийн биелэлтийг хангаж ажилладаг билээ.

Зөвлөмжийн 14-т “Улс орнууд мөнгө болон үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ”-г тусгай зөвшөөрөлгүй, эсвэл бүртгэлгүй эрхэлсэн хувь хүн, хуулийн этгээдийг илрүүлж, холбогдох арга хэмжээг авч ажиллана” гэж заасан байдаг. Хороо өнгөрсөн хугацаанд Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ), Цагдаагийн ерөнхий газар (ЦЕГ)-ын Эрүүгийн цагдаагийн алба (ЭЦА) мөн Хорооны орон нутгийн төлөөлөгчидтэй тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагааг илрүүлэх шат дараалсан арга хэмжээнүүдийг авч ажилласаар ирлээ. Ийнхүү ирүүлсэн мэдээлэлд үндэслэн хяналт шалгалт хийх, Зөрчлийн тухай хуульд заасан арга хэмжээг авах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Уг ажлыг



албажуулах, зөвшөөрөлгүйгээр цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхэлсэн хувь хүн хуулийн этгээдийн үйл ажиллагааг олж тогтоох, хянан шалгах, таслан зогсоох, олон нийтэд мэдээлэх, мэдээллийн сан үүсгэхтэй холбоотой харилцааг зохицуулж, хянан шалгагч нарт зориулсан “Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, гадаад валютын арилжааг тусгай зөвшөөрөлгүй эрхэлж буй этгээдийг олж тогтоох, хяналт тавих, мэдээлэх заавар”-ыг баталлаа.

“МОНГОЛ УЛСАД МӨНГӨ УГААХ БОЛОН БУСАД САНХҮҮГИЙН ГЭМТ ХЭРЭГТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ ХУУЛЬ БУСААР АШИГЛАХ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ”-Г ХИЙЛЭЭ

Олон улсын санхүүгийн хориг хэрэгжүүлэх байгууллага (FATF)-ын Ази, Номхон далайн бүсийн байгууллага (APG)-аас Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд хийсэн 2017 оны харилцан үнэлгээний тайланд Монгол улс хуулийн этгээдийн эрсдэлийн

үнэлгээг хийж гүйцэтгээгүй байгаа тул Зөвлөмж 24 (шалгуур үзүүлэлт с.24.2) “хэсэгчлэн биелсэн” үнэлгээ авч байсан.

Үүнийг хэрэгжүүлэх үүднээс Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 327 дугаар тогтоолын хавсралтаар “Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г баталж, уг төлөвлөгөөний 5.7-д Монгол Улсад мөнгө угаах болон бусад санхүүгийн гэмт хэрэгт хуулийн этгээдийг хууль бусаар ашиглах эрсдэлийн үнэлгээг Хороо үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаар, Санхүүгийн мэдээллийн алба, Улсын бүртгэлийн газар, Цагдаагийн ерөнхий газар, Татварын ерөнхий газартай хамтран хийж гүйцэтгэхээр тусгагдсан.

Дээрх төлөвлөгөөний хүрээнд Хорооны даргын 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 641 дүгээр тушаалаар Хуулийн этгээдийн эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсэг байгуулагдаж, тус ажлын хэсэг “Монгол улсад мөнгө угаах болон бусад санхүүгийн гэмт хэрэгт хуулийн этгээдийг хууль бусаар ашиглах эрсдэлийн үнэлгээ”-г хийж гүйцэтгэлээ.



БАЙР СУУРЬ



Д.БОЛДМЯГМАР

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗРЫН АХЛАХ ЗӨВЛӨХ

Та Банк бус санхүүгийн салбарын өнөөгийн нөхцөл байдал болон СЗХ-оос хэрэгжүүлж буй бодлого, зохицуулалтын талаар мэдээлэл өгнө үү?

2019 оны 2 дугаар улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд нийт 538 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаагаа явуулж байна. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасны дагуу банк бус санхүүгийн байгууллагууд нийт 10 төрлийн үйлчилгээг Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх боломжтой байдаг. Оны эхний улирлын байдлаар 492 банк бус санхүүгийн байгууллага буюу 91.4 хувь нь зээлийн үйл ажиллагаа, 155 банк бус санхүүгийн байгууллага буюу 8.6 хувь нь гадаад валют арилжааны үйлчилгээг дагнан эрхэлж байна. Салбарын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж буй банк бус санхүүгийн байгууллагуудын 86.1 хувь нь нийслэл Улаанбаатар хотод явуулж байгаа бөгөөд Монгол Улсын 21 аймагт нийт 75 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулж, орон нутгийн иргэдэд хүрч үйлчилж байна.

Банк бус санхүүгийн байгууллагуудыг бие даасан, тогтвортой, эрсдэлийг даван туулах чадвартай мэргэжлийн санхүүгийн институц болгох, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийн нэмэгдүүлэх, цаашлаад зээлийн хүүг бууруулах нөхцөлийг бий болгох зорилгоор тэдгээрийг чадавхжуулах бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Уг ажлын хүрээнд шинээр

банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 2016 оны 272 дугаар тогтоолоор, Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 2017 оны 27 дугаар тогтоолоор тус тус шинэчлэн тогтоож өгсөн. 92 дугаар тогтоолоор хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 4 жилийн туршид үе шаттай нэмэгдүүлэхээр тогтоомж өгсөн бөгөөд зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулж Улаанбаатар хотод 2.5 тэрбум, Орхон аймгийн Баян-Өндөр, Дархан-Уул аймгийн Дархан сумдад Улаанбаатар хотоос ялгавартай буюу 600 сая, бусад аймаг сумдад харьцангуй доогуур буюу 200 сая төгрөгөөр тогтоож өгсөн нь хөдөө орон нутагт банк бус санхүүгийн байгууллага байгуулахыг дэмжиж, ингэснээр тэр бүрийн санхүүгийн үйлчилгээ авч чаддаггүй хөдөө орон нутгийн иргэдэд хүрч үйлчлэх, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой.

2019 оны хоёрдугаар улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгийн хэмжээ 1.5 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 34.0 хувь буюу 389.4 тэрбум төгрөгөөр нэмэгдээд байна. Банк бус санхүүгийн байгууллагуудын хөрөнгийн чадавх сайжирч, эх үүсвэрийн хэмжээ нэмэгдсэн, дэвшилтэт технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ зах зээлд идэвхтэй нэвтэрч эхэлсэнтэй холбоотой салбарын зээлийн нийлүүлэлт, хүртээмж нэмэгдсэнээр 2019 оны хоёрдугаар улирлын байдлаар салбарын нийт харилцагчдын тоо 2.3 саяд, нийт зээлдэгчдийн тоо 360.3 мянгад хүрч хурдацтай өсөж байна. Банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэж нийт зээлийн үлдэгдэл 1.1 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеийнхээс 328.4 тэрбум төгрөг буюу 42.7 хувиар өссөн үзүүлэлт юм. Банк бус санхүүгийн байгууллагууд банкнаас санхүүгийн үйлчилгээ авч чаддаггүй, харьцангуй эрсдэл өндөртэй бүлэгт түргэн шуурхай, амар хялбар

байдлаар үйлчилгээрээ онцлог. Олгосон нийт зээлийн үлдэгдлийн 84.7 хувийг иргэдийн, 15.3 хувийг хуулийн этгээдийн зээлийн үлдэгдэл тус тус бүрдүүлж байна. Зээлийн чанарын хувьд 87.2 хувийг хувийн, 3.9 хувийг хугацаа хэтэрсэн, 8.9 хувийг чанаргүй зээл тус тус эзэлсэн бөгөөд чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хэмжээ 1.5 пунктээр бууж зээлийн чанар сайжирсан. Зээлийн жигнэсэн дундаж хүүгийн хувьд 3.3 хувьтай байгаа бөгөөд энэ нь 2018 оны мөн үетэй ижил байна.

Банк бус санхүүгийн салбарын эрх зүйн зохицуулалтын орчин ямар байна вэ?

УИХ-аас Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль 2002 онд баталсан бөгөөд банк бус санхүүгийн байгууллагууд УИХ-аас 2005 онд Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийг батлахаас өмнө Монголбанкны хяналт, зохицуулалтын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг байсан. Хууль батлагдсанаас хойш нэлээдгүй хугацаа өнгөрсөн бөгөөд Захиргааны ерөнхий хуулинд нийцүүлэх, үйл ажиллагаа явуулах таатай нөхцөлийг бүрдүүлэх, үйл ажиллагааны цар хүрээг өргөтгөх, олон улсын туршлагад нийцүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалт, оновчтой хяналт зохицуулалтын тогтолцоог нэвтрүүлэх зэрэг шалтгаанаар хуулийг шинэчлэн найруулах шаардлага үүсээд байна. Түүнчлэн Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 2018–2019 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдэд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах, УИХ-аар батлуулах ажлууд тусгагдсан. Үүнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны даргын 2018 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 68 дугаар тушаалаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн

төсөл боловсруулах, төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоолол хийх, төслийг хэлэлцүүлж санал авах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж, хуулийн төслийг боловсруулаад байна. Одоогийн байдлаар Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк /ЕСБХБ/-наас хууль эрх зүйн орчныг сайжруулахтай холбоотой техникийн туслалцаа авч ажиллаж байгаа бөгөөд хуулийн төсөлд олон улсын тэргүүн туршлагыг тусгах, санал, зөвлөмжийг өгөхөөр хуулийн зөвлөхүүд ажиллаж байна. Удирдлагуудын зүгээс УИХ-ын намрын чуулганаар оруулах байр суурьтай байна. Түүнээс гадна салбарын журам, захиргааны хэм хэмжээний актуудыг боловсронгуй болгохоор ажиллаж байна. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13.4 дэх заалтыг үндэслэж Хорооноос банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үйл ажиллагааны болон өөрийн хөрөнгийн зохистой харьцааг тогтоох замаар тогтвортой байдлыг хангуулах, хяналтыг сайжруулахтай холбоотойгоор “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ын төслийг шинэчлэн боловсруулж, олон нийтээр хэлэлцүүлээд Хорооны 2019 оны 210 дугаар тогтоолоор батлаад байна.

Тус салбарын хөгжил технологиор дамжуулж хурдацтай хөгжих төдийгүй хөрөнгийн зах зээлтэй давхар уялдаж буй хандлагыг хэрхэн харж байгаа вэ?

Хурд, автоматчлал, амар хялбар байдлаар ялгарах “Аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгал”-ын эрин үе нь дэлхий дахинаа эрүүл мэнд, аялал жуулчлал, үл хөдлөх хөрөнгө зэрэг олон салбаруудад өөрчлөлт, шинэчлэлийг авчраад байгаа бөгөөд тэр дундаа санхүүгийн салбарт онцгой нөлөө үзүүлээд байна. Дэвшилтэт технологи дээр суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээ нь хэрэглэгчдэд цаг хугацаа, орон зайнаас

үл хамааран санхүүгийн үйлчилгээ авах боломжийг олгохоос гадна эдгээр бүтээгдэхүүн, үйлчилгээ нь хэрэглэгчдэд ая тухтай, амар хялбар, түргэн шуурхай байдгаараа уламжлалт санхүүгийн бүтээгдэхүүнээс давуу талтай. Технологи дээр суурилсан, ухаалаг гар утасны аппликейшнд суурилсан санхүүгийн үйлчилгээ нь гэнэтийн санхүүгийн хэрэгцээ гарсан, яаралтай бага хэмжээний мөнгөний шаардлага үүссэн бүлэгт хүрч үйлчилдэг бөгөөд цаг хугацаа, орон байршлаас үл хамаарсан, барьцаа хөрөнгөгүйгээр зээлийн үйлчилгээг хүртэх боломжийг олгож байна. Уг үйлчилгээг авсан нэг иргэнд ногдох зээлийн дүн 336.0 мянга байна. Эдгээр нь өрсөлдөөнийг дэмжих, бүтээгдэхүүн үйлчилгээний үр ашгийг нэмэгдүүлснээр санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх томоохон хөшүүрэг болж байна. Сүүлийн жилүүдэд дэвшилтэт технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлж байгаа банк бус санхүүгийн байгууллагуудын тоо нэмэгдэж, технологийн цоо шинэ шийдлийг нэвтрүүлж, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд арилжааны банктэй өрсөлдөхүйц түвшинд аль хэдийн хүрээд байна. Нэгдүгээр улирлын байдлаар салбарын нийт зээлдэгчдийн 63.2 хувь нь дэвшилтэт технологид суурилсан зээлийн үйлчилгээг хүртсэн бөгөөд уг үйлчилгээг хүртэж буй зээлдэгчдийн тоо эрчимтэй нэмэгдсээр байна. Үүний сацуу технологи боловсронгуй болохтой зэрэгцээд залилан, мэдээллийн нууцлал, аюулгүй байдал зэрэг эрсдэлүүд дагаж үүсдэг. Эдгээр эрсдэлүүдийг хаах зохицуулалт шаардлагатай зэрэгцээ цахим санхүүгийн үйлчилгээ нь уламжлалт санхүүгийн үйлчилгээнээс үйл ажиллагааны онцлог, эрсдэлийн түвшин, бизнесийн загвар зэрэг зарчмын ялгаатай тул оновчтой хяналт зохицуулалт шаардлагатай. Түүнээс гадна одоогоор “Лэндмн ББСБ” ХК, “Инвескор ББСБ” ХК, “Ардкредит ББСБ” ХК зэрэг банк бус санхүүгийн байгууллагууд IPO

гаргаж хувьцаагаа олон нийтэд амжилттай арилжаалаад байгаа бөгөөд ингэснээр банк бус санхүүгийн байгууллагууд хувьцаа эзэмшүүлэх, үр ашгаа хуваах боломжтой болсон.

Дунд хугацааны 5–10 жилд банк бус санхүүгийн салбарын хөгжлийн түвшинг хэрхэн зураглаж байгаа вэ?

Дээр дурдсанчлан Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийг боловсронгуй болгохоор хуулийн төсөл дээр ажиллаж байна. Хууль батлагдсанаар бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл нэмэгдэж, үйл ажиллагааны цар хүрээ тэлж, эрх зүйн таатай орчин бүрдэх юм. Дунд хугацаанд санхүүгийн салбарт банк бус санхүүгийн салбарын эзлэх хэмжээг нэмэгдсэн, бүтээгдэхүүн үйлчилгээний төрөл ангилал нэмэгдсэн, зээлийн хүүгийн хэмжээ харьцангуй буусан байхаар зураглаж байна. Харин Хорооноос одоо явуулж буй чадавхжуулах хөтөлбөрийн үр дүнд банк бус санхүүгийн байгууллагууд тооны хувьд гэхээсээ илүү чанарын хувьд өссөн, илүү мэргэжлийн, арилжааны банкуудтай өрсөлдөхүйц хэмжээнд хүрсэн байна гэж харж байгаа. Мэргэжлийн өндөр ёс зүйтэй, компанийн засаглал сайтай, илүү хариуцлагатай банк бус санхүүгийн салбарыг бүрдүүлэх нь нэн чухал болоод байна. Иймд банк бус санхүүгийн байгууллагуудыг сургалт, семинар, чадавхжуулах хөтөлбөрүүдэд идэвхитэй хамруулах бөгөөд төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэн бататгаж, мэргэжлийн холбоотой үр ашигтай хамтран ажиллана. Түүнчлэн төлөвлөгөөт хяналт шалгалтаас эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоонд бүрэн шилжихээр, зээлийн батлан даалтын сангийн үйлчилгээнд банк бус санхүүгийн байгууллагуудыг идэвхитэй хамруулах, бага хүүтэй, урт хугацаатай бөөний зээлийг банк бус санхүүгийн байгууллагуудаар дамжуулан зээлдүүлэх боломжийг эрэлхийлэх хүрээнд холбогдох арга хэмжээг авч ажиллана. Эдгээрээс гадна төрийн үйлчилгээг



илүү чанартай, түргэн шуурхай, зардал чирэгдэл багатай үзүүлэх хүрээнд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл авах үйл ажиллагаа бүрэн цахимжуулахаар ажиллаж байна. Технологийн үсрэнгүй хөгжил, оновчтой бодлого, зохицуулалтын үр дүнд финтек суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээний нийлүүлэлт, хүртээмж нэмэгдэж энэ төрлийн үйлчилгээ илүү боловсронгуй болно. Иргэдийн санхүүгийн мэдлэгийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж, ерөнхий мэдлэг мэдээлэл өгөхөөс гадна финтек суурилсан үйлчилгээг хэрэглэх, хувийн мэдээлэл, мэдээллийн нууцлалын талаар гэх мэтчилэн харилцагчийг хамгаалах үүднээс цаг үеэ дагасан илүү хэрэгцээтэй мэдээллийг түгээж ажиллана. Мэдээж технологи асар хурдан хувьсан өөрчлөгдөж, илүү их боломжийг нээж өгч байгаагийн хэрээр эрсдэлийн хэмжээ зэрэг нэмэгдсээр байдаг. Үүнтэй холбоотой харилцагчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хамгаалах тогтолцоог бүрдүүлж ажилласан байна гэж итгэж байна. Түүнчлэн дэлхийн хэмжээнд дараалсан хамгийн халуун жилүүд тохиогоод байна. Уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарлын эсрэг төр болон төрийн бус байгууллагууд аль аль талдаа онцгой анхааралдаа авч, арга хэмжээ авч ажиллаж байна. Хорооны зүгээс уур амьсгалын өөрчлөлт, цаг уурын дулаарлын эсрэг эдийн засгийн ногоон үйл ажиллагааг дэмжин ажиллах бөгөөд Банк бус санхүүгийн салбарт ногоон санхүүжилтийг идэвхижүүлэх хүрээнд мэргэжлийн оролцогчдын ухамсар ойлголтыг нэмэгдүүлэх, холбогдох стандарт, зарчмыг тогтоох, байгаль орчны эрсдэлийн үнэлгээг нэвтрүүлэх арга хэмжээг авч ажиллах болно.

Цаг уурын өөрчлөлттэй холбоотойгоор дэлхий нийтийн хэмжээнд ногоон эдийн засаг, тогтвортой санхүүжилтийн асуудал чухалд тооцогдох болоод байна. Тэгвэл Хорооноос ямар арга хэмжээ авч ажиллаж байгаа вэ? Хорооны байр суурь?

Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт нь дэлхий дахинд тулгамдаад буй томоохон

асуудлын нэг болоод байна. Дэлхийн агаарын хэм 1880 оноос хойш буюу зуу гаруйхан жилийн дотор 0.9 цельсээр нэмэгдсэн, арктикийн мөс 10 жилийн дотор 12.8 хувиар багасаж, хүлэмжийн хийний хэмжээ 1990–ээд оноос хойш 50 хувиар нэмэгдэж, усны түвшин зуу гаруйхан жилд 19 см–ээр нэмэгдэж, далай тэнгис, гол мөрөнгийн хүчиллэг байдал хог хаягдлаас болж нэмэгдэж, мөн газар хөдлөлт, цунами, хар салхи, үер зэрэг байгалийн гэнэтийн гамшигт үзэгдлүүд 1970–аад оноос хойш 400 хувиар нэмэгдэж, ан амьтан устаж үгүй болох, цөлжих, хэт дулаарах, хүмүүсийн амь нас эрүүл мэндэд заналхийлэх зэрэг томоохон аюул дэлхий дахинд нүүрлээд байна. Үүнтэй холбоотой Парисын хэлэлцээрийг баталж, 2030 он гэхэд дэлхийн дулаарлын өсөлтийг 2 цельс, боломжтой бол 1.5 цельсээс доош түвшинд барих зорилго тавьсан бөгөөд Монгол Улс нэгдэн орсон. Мөн НҮБ-ын Тогтвортой санхүүжилтийн зорилтод “Хүлэмжийн хийний ялгарлыг 40 хувиар бууруулах” гэсэн заалт багтсанаас гадна Монгол улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлэх бодлогын зорилт, арга хэмжээний Зорилго 7.3.1–т “Санхүүгийн салбарт тогтвортой санхүүжилтийн зарчмыг цогцоор нь нэвтрүүлэх” гэж заасан. Дээрх байгаль орчинд хор хөнөөлтэй үйл ажиллагааг санхүүжүүлж буй байгууллагуудын хувьд өөрийн хувь нэмрийг оруулж, өөрчлөлтийг хийх боломжтой. Иймд санхүүгийн системийг ногооруулах, бодлогоор дэмжих, ногоон зээлийг нэвтрүүлэх зайлшгүй шаардлага үүсээд байна.

Санхүүгийн зохицуулах хороо нь 2006 онд “Санхүүгийн хүртээмжийг нийгэмлэг” олон улсын байгууллагын гишүүн байгууллагаар элссэн бөгөөд одоогоор 6 ажлын хэсэгт орж ажиллаж байна. Энэ онд нэмж ногоон санхүүжилтэд чиглэсэн ажлын хэсгийг шинээр байгуулагдаж, Хорооноос миний бие үндсэн гишүүнээр ажиллаж байгаа. Байгал орчинд ээлтэй үйл ажиллагааг таньж

мэдэх, түүний ач холбогдлыг таниулах үйл явц нь нэн чухал бөгөөд нэгдсэн ойлголт, нэг стандарттай болсноор түүний эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг тооцоолж үнэлэх, улмаар бодит мэдээлэл, нотолгоонд суурилсан арга хэмжээг авснаар нийт эдийн засаг дахь тогтвортой өсөлтийг хангах боломж үүснэ. Манай улсын банкнаас бусад санхүүгийн салбарын хувьд ногоон зээлийн бүтээгдэхүүн санал болгож буй цөөн банк бус санхүүгийн байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна. Хорооны зүгээс эхний ээлжинд ногоон эдийн засагт чиглэсэн үйл ажиллагаа явуулж буй, мөн үйл ажиллагаа явуулах сонирхолтой оролцогчдыг дэмжих, тэдгээр байгууллагуудын ногоон эдийн засгийн талаарх ухамсар, ойлголтыг нэмэгдүүлэх бодлого баримталж байгаа бөгөөд ногоон зээлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч ажиллахаар төлөвлөж байна. Дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлтөөс сэргийлэх, түүнд дасан зохицох үйл ажиллагааг дэмжих хүрээнд дэлхий нийтээр зовних болсон төдийгүй олон улсын байгууллагууд хөгжиж буй орнуудад дэмжлэг туслалцаа үзүүлэх хандлага дэлгэрч байна. Манай орны хувьд ч хамтрагч байгууллагуудаас тус төрлийн туслалцааг авч, бодлогын хэрэгжилтийн үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх, идэвхижүүлэх боломжтой. Иймд Хороо энэ онд “Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг”–ээс 200 банк бус санхүүгийн байгууллагыг хамруулсан боловсон хүчинг чадавхжуулах хөтөлбөр, сургалт зохион байгуулах чиглэлээр туслалцаа хүсээд байна. Түүнчлэн Ногоон санхүүжилтийн орчныг дэмжих, хууль эрхзүйн таатай орчныг бүрдүүлэх асуудал нь Хорооны хувьд дунд хугацааны бодлогын нэгэн эд эс болж байгаа. Бид холбогдох арга хэмжээг “Санхүүгийн зохицуулах хорооны стратеги төлөвлөгөө (2018–2021)”–д тусгаснаас гадна “Санхүүгийн хүртээмжийн үндэсний стратеги”–ийн төсөлд дэд зорилт болгон, холбогдох арга хэмжээг тусган, тус баримт бичгийг боловсруулах шатандаа явж байна.

ФИНТЕК БА РЭГТЕК

**ФИНТЕК БА ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ**

Финтек нь гүйлгээний зардлыг бууруулж, капиталын үр ашигтай байдлыг нэмэгдүүлдэг.

Шинэ технологийн тусламжтайгаар гүйлгээний зардал болон хугацааг багасгаж, хөрөнгийн зарцуулалтыг хянах боломжтой болсноор үйл ажиллагааны үр ашигтай байдал ерөнхийдөө нэмэгддэг. Газар тариаланд big data буюу том датаг ашиглан температур, чийг, хур тунадас зэрэг ургацын ургах орчинг хянах боломжтой болно. Цаашлаад энэ нь зээл, даатгал зэрэг санхүүгийн салбарт ашиглагдах боломжтой болдог.

Жишээ. Big data ашиглалт

Хөдөө аж ахуйн хувьд үр ашиггүй нийлүүлэлтийн гинжин хэлхээ, зах зээлийн хүртээмжид тулгарах саад, бэрхшээлүүдээс болоод олон тооны жижиг үйлдвэрлэл эрхлэгч, фермерүүд эдийн засгийн болон нийгмийн хожоогоо алдаж байдаг. Вьетнам улсад BanQu корпораци блокчэйнийг ХАА-д нэвтрүүлснээр фермерүүд гар утсаа ашиглан өөрсдийн болон газрынхаа мэдээллийг

агуулсан хувийн хэргийг үүсгэснээр BanQu сүлжээнд нэвтрэн үйл ажиллагаагаа хялбараар явуулах боломжтой болж байна. Ингэснээр фермерүүдийн хувьд газар болон бүтээгдэхүүнийхээ үнэлгээг бодитоор үнэлүүлж, даатгалд хамрагдаж, ургацын хэмжээг таамаглах боломжтой болж байгаа юм.

Блокчэйний нөлөө

Финтек компаниуд блокчэйнийг ашиглан байгалийн нөөц баялгийг дижитал хэлбэрт оруулж байна. Ил тод байдлыг нэмэгдүүлдэг учир блокчэйнийг ашигласнаар бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхой болгож тэгш бус мэдээллийн эрсдэлийг бууруулж байна.


Жишээ 1. Нийлүүлэлтийн гинжин хэлхээний ил тод байдал

Нийлүүлэлтийн гинжин хэлхээний ил тод байдал нь тогтвортой хөгжилд нөлөө үзүүлдэг финтекийн хамгийн түгээмэл жишээ байдаг. Блокчэйнийг ашиглан хөрөнгийн урсгалыг ил тод болгосноор энэ нь цаашлаад ой мод, загас ан агнуураас эхлээд нүүрсхүчлийн хий болон эрчим хүч ашиглалт зэрэг байгалийн

нөөц баялагийн хэрэглээ, ашиглалтыг хянах боломжтой болгодог. Индонезид нийлүүлэлтийн тогтвортой гинжин хэлхээг үүсгэх зорилготой блокчэйний төслийг хэрэгжүүлж эхлээд байгаа нь орон нутгийн загасчидын барьсан үсэрдэг загас болон шар судалт тунаны гарал үүслийг тодорхой болгож, комплаенсийг нэвтрүүлэн одоогийн гарал үүслийг бичигт тогтолцоог халах боломжтой болгож байгаа юм. Үүнээс гадна энэхүү төсөл амжилттай хэрэгжвэл загас их хэмжээгээр барих (overfishing), залилан, хууль бус загасчлал буурна гэж үзээд байна.

Жишээ 2. Нүүрсхүчлийн хийн ялгарлын зөвшөөрөл

Зарим улс орнууд компаниудын ялгаруулдаг нүүрсхүчлийн хий болон бусад хүлэмжийн хийг багасгах үүднээс carbon credit буюу нүүрсхүчлийн хийн ялгарлын зөвшөөрлийг олгодог байна. Энэхүү хөтөлбөр нь илүү хэмжээний зөвшөөрлөө наймаалцах буюу худалдах боломжийг олгодог буюу сар-and-trade нэрээр алдаршсан. Компаниуд нүүрсхүчлийн ялгарлын дээд хязгаарт тохируулан үйлдвэрлэлээ явуулж, тэрнээс давж ялгарах тохиолдолд зөвшөөрлийг



засгийн газраас эсвэл бусад компаниудаас худалдаж авдаг. Гэхдээ нүүрсхүчлийн хийн ялгарлыг тооцох болон зөвшөөрлийг солилцох нь цаг их шаардсан, өртөг өндөртэй үйл ажиллагаа учраас энэхүү тогтолцоог илүү боловсронгуй болгох үүднээс блокчэйнийг нэвтрүүлж эхэлсэн. Блокчэйний тусламжтайгаар компанийн ялгаруулж байгаа хэмжээг тодорхойлоод зогсохгүй цаашлаад зөвшөөрлийн илүү эсвэл дутууг биржийн бус аргаар наймаалцах боломжтой болж байна.

Финтек нь ногоон санхүүжилтийг өргөн хүрээтэй болгодог.

Том датаны тусламжтайгаар зөвхөн тухайн хүнд зориулсан маркетинг явуулж чаддагаараа финтек компаниуд бага зардлаар илүү олон хэрэглэгчийг ногоон санхүүжилтэд нэгтгэж чаддаг.

Жишээ. P2P буюу peer-to-peer эрчим хүчний "гүйлгээ"

Prosumers (Producer + consumer) буюу хэрэглэгч-үйлдвэрлэгчид нь өөрсдөө эрчим хүчийг ашиглаад зогсохгүй нар, салхины буюу сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг ашиглан үүсгэсэн эрчим хүчийг блокчэйн технологийг ашиглан "хөрш"-дөө худалдах боломжтой болж байна. Үр дүнд нь блокчэйнд суурилснаар эрчим хүчний хэрэглээ банк, эрчим хүчний компаниудаас хамааралгүй болж байна. Оронд нь нэг төвтэй биш эрчим хүчний гүйлгээ болон нийлүүлэлтийн систем хөгжиж хэрэглэгчид өөрсдийн хэрэглэж буй болон худалдаж буй эрчим хүчээ хянах боломжтой блокчэйнд суурилсан ухаалаг гэрээний тоо нэмэгдэнэ. P2P эрчим хүчний гүйлгээ нэмэгдсэнээр байгальд ээлтэй буюу сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ өснө гэж үзэж байна.

Финтек нь ногоон амьдралын хэв маягийг сурталчилдаг

Жишээ. БНХАУ дахь ногоон финтек буюу "Ant Forest"

БНХАУ-д тэргүүлэх финтек компани болох ANT санхүүгийн нэгдэл нь хэрэглэгчдэд ногоон санхүүжилтийг сурталчлах зорилгоор өргөн хүрээний төслийг хэрэгжүүлээд байна. Компаниас интернет, санхүү болон "low-carbon lifestyle" буюу нүүрсхүчлийн хийн бага ялгаралтай амьдралын хэв маягийг нэгтгэн гаргасан "Ant Forest" аппликэйшн нь Ant-ийн хэрэглэгчдэд өөрсдийн ялгаруулсан нүүрсхүчлийн хийг багасгах боломжийг олгож байна. Ингэхдээ (a) хэрэглэгчид ухаалаг гар утаснаасаа нүүрсхүчлийн хийг багасгахад оруулсан хувь нэмрээ харах боломж, (b) виртуал хаягийг нь "ногоон эрчим хүч"-ээрх орлоготой болгох, (c) тухайн орлогоор нь мод тарьж урамшуулах гэсэн гурван алхамт хөтөлбөрийг нэвтрүүлэн ажиллаж байна. Хэрэглэгчид алхах, эсвэл олон нийтийн унаагаар зорчих мөн хэрэглээний зардал, торгууль, эмнэлгийн зардлаа онлайнээр төлөх зэрэг нүүрсхүчлийн хийн ялгарал багатай үйл ажиллагааг хийсэн нь тооцоологдож, "ногоон эрчим хүч"-ийг дансандаа нэмнэ. Ногоон эрчим хүч нь виртуал дансандаа виртуал мод тарих хангалттай хэмжээнд хүрэхэд Ant санхүүгийн нэгдэл болон хамтран ажиллагч байгууллагуудын зүгээс бодитоор мод тарьдаг байна.

Гайхалтай нь уг хөтөлбөр төсөөлж байснаас хамаагүй олон хэрэглэгчийг хамарч богино хугацаанд хамарч чадсан байна. 2016 оны 8 дугаар сараас 2017 оны 1 дүгээр сар хүртэлх 6 сарын хугацаанд БНХАУ-ын 200 гаруй сая иргэн сайн дураараа аянд нэгдсэн нь Ant-ийн хэрэглэгчдийн 44%, БНХАУ-ын насанд хүрсэн хүн амын 20% буюу дэлхийн хүн амын 3%-тай тэнцэж байна. Энэхүү амьдралын хэв маягийн өөрчлөлт нь үүсч болох байсан 150,000 тонн нүүрсхүчлийн хийн ялгарлаас сэргийлж, Ant санхүүгийн нэгдэл 2017 оны 1 дүгээр сар гэхэд 1 сая мод, 2019 он гэхэд 100 сая модыг 933 км² буюу 130,000 хөлбөмбөгийн талбайтай тэнцэх талбайд суулгажээ.

Make the Planet Greener One Tree at a Time | 支付宝 Alipay | ANT FOREST

500 million users
Equivalent to the combined populations of the US, Germany and France

100 million trees, covering 933 sq km, have been planted
Equivalent to 500 times the number of trees in Central Park, New York
Equivalent to 130,000 soccer pitches combined

Beneficial regions
Inner Mongolia, Gansu, Qinghai, Shanxi

Other fun features
Co-planting with family, friends and loved ones
Collecting energy from friends
Watering trees for friends

How to grow a virtual tree and make it real

- Using shared bikes: 20g
- Green takeout: 20g
- Walking: 60g
- Online payment: 5g
- Public transport: 5g

1 Engage in low-carbon activities
2 Earn green energy points
3 With enough points, Ant Forest and their philanthropic partners will plant a real tree

СУДЛААЧИЙН ИНДЭР

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ ДЭХ НОГООН САНХҮҮЖИЛТ

Арилжаа эрхлэх байгууллага esg-г дэмжих нь

Тогтвортой хөгжлийг дэмжих зорилтуудыг хангах тогтвортой бизнес болон хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэсэн үнэт цаасны зах зээлд баримтлах бодлого, хөрөнгө оруулалтын хэрэгслүүд нь хөрөнгө оруулалтын талбарт маш чухал байр суурийг эзэлж байна. Шинэ бодлого боловсруулах, шинэ хөрөнгө оруулалтын арга хэрэгслийг нэвтрүүлэх гол тоглогчид нь арилжаа эрхлэх байгууллага, мэргэжлийн хөрөнгө оруулагчид /хөрөнгө удирдлагын менежерүүд болон хөрөнгө эзэмшигчид/ болон зохицуулагч байгууллагууд билээ.

Улс орнуудын арилжаа эрхлэх байгууллагаас авч хэрэгжүүлж буй тогтвортой хөгжлийг дэмжих үйл ажиллагаанууд нь тогтвортой санхүүгийн зах зээлд гарч буй жишиг арга хэрэгсэл юм.

Нэгдсэн үндэсний байгууллагаас гаргадаг Дэлхийн хөрөнгө оруулалтын тайлан 2018-д дэлхийн 54 арилжаа эрхлэх байгууллага Байгаль орчин, нийгэм, засаглалын зарчмыг анхааралдаа аван холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа талаар онцолжээ.

Зураг 1. Тогтвортой санхүүжилтийг хэрэгжүүлж буй арилжаа эрхлэх байгууллагын тойм




Эх сурвалж: UNCTAD, SSE initiative database.

2009 онд Нэгдсэн Үндэсний Байгууллагаас Тогтвортой Биржүүд / Sustainable Stock Exchanges (SSE)/ санаачилгыг хэрэгжүүлсэн бөгөөд, биржүүд SSE-ийн олон талуудыг холбосон платформоор дамжуулан хөрөнгө оруулагчид, бүртгэлтэй компаниуд, хөрөнгийн зах зээлийн зохицуулагч байгууллагууд болон бодлого боловсруулагчидтай зөвшилцөж, чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаанд оролцож, мэдээлэл солилцдог байна.

2018 оны 3 дугаар улирлын байдлаар 81 их наяд ам.долларын зах зээлийн үнэлгээ бүхий 45,700 бүртгэлтэй компанитай 5 тивийн 78 бирж SSE-д нэгдсэн байна.

Зураг 2. SSE-д бүртгэлтэй гишүүд



Эх сурвалж: SSE database.


Ногоон санхүү болон ESG индекс

Арилжаа эрхлэх байгууллагууд болон хөрөнгийн зах зээлийн бусад оролцогчид ногоон бүтээгдэхүүнийг дэмжих, мөн уламжлалт санхүүгийн зах зээлийг “ногоонжуулах” нь дэлхийн дулаарлаас үүдсэн уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд маш чухал ач холбогдолтой.

Дэлхийн дундаж дулаарлыг цельсийн 2 градусын хэмээр бага байлгахад эрчим хүчний салбарт 2012–2050 он хүртэл жил бүр 1 их наяд ам.долларын хөрөнгө оруулалтыг хийх шаардлагатай байгаа талаар Олон улсын эрчим хүчний агентлагаас тооцоолон гаргасан.

Сүүлийн жилүүдэд Ногоон бонд гаргах нь эрчимтэйгэйгээр өсч, нийт ногоон бондод оруулах хөрөнгө оруулалтын дүн 2017 оны эцсийн байдлаар 163 тэрбум ам. долларт хүрчээ. Энэ нь 2016 оноос 167 хувиар өссөн үзүүлэлт юм. АНУ-ын санхүүгийн үйлчилгээний салбарын Мүүди үнэлгээний байгууллагаас гаргасан таамаглалаар 2019 онд ногоон бондод оруулах хөрөнгө оруулалт 200 их наяд ам. доллар давах хандлагатай байгаа юм.

Зураг 3. Ногоон бондод оруулсан хөрөнгө оруулалт /их наяд ам.доллар/




Эх сурвалж: UN Environment and Bloomberg

ESG индекс нь арилжаа эрхлэх байгууллагуудын хувьд тогтвортой санхүүжилтийн хамгийн түгээмэл арга хэрэгсэл бөгөөд SSE мэдээллийн санд бүртгэлтэй 87 биржийн 40 нь тус индексийг тооцож гаргадаг байна. Мөн биржүүдээс гадна FTSE–Russel, Standard & Poor’s, Dow Jones, Stoxx, Thomson Reuters, MSCI зэрэг байгууллагууд ESG индексийг тооцож байна.

Тухайлбал, 1990 оноос тооцож эхэлсэн Байгаль орчин, нийгэм, засаглалын өндөр үнэлгээтэй 400 америк компанийн зах зээлийн үнэлгээнд суурилсан MSCI KLD 400 Social Index нь 2013–2017 онуудын 4 жилд нь S&P 500 индексийг давжээ.

Зураг 4. ESG индекс болон уламжлалт зах зээлийн индексийн өгөөж /хувиар/



Эх сурвалж: SSE database.

ЗЭЭЛИЙН ЗАХ ДЭЭЛ ДЭХ НОГООН САНХҮҮЖИЛТ

Ард иргэдийнхээ амьдралын чанарыг сайжруулан, ядуурлыг бууруулж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх нь олон улс орны бодлого гаргагчдын чухал зорилт байдаг. Харин энэхүү зорилтыг хангах явцад байгаль орчны асуудал чухлаар хөндөгддөг. Grossman болон Krueger нар эдийн засгийн хурдтай өсөлт нь байгаль орчин, экологийн асуудалд сөрөг нөлөөлдөг үү гэсэн асуулыг 1994 онд анх тавьсан байдаг. Хүний амьдралд байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал хэчнээн чухал болохыг бодолцолгүйгээр зөвхөн эдийн засгийн хөшүүрэгт үндэслэн хийсэн байгаль орчинд хор нөлөөтэй хүний олон үйл ажиллагаа байдаг хэдий ч сүүлийн жилүүдэд эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагаан дахь байгаль орчны асуудал, түүний ач холбогдол эрчимтэй яригдаж, байгаль орчны доройтлолтой тэмцэх, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад санхүүгийн зах зээл чухал үүргийг гүйцэтгэж байна.


Гэсэн хэдий ч байгаль орчинд ээлтэй ногоон үйлдвэрлэл, уур амьсгалын өөрчлөлт, орчны доройтлыг бууруулахад чиглэсэн төслүүд нь энгийн бизнесийн төсөлтэй харьцуулахад илүү их хөрөнгө зардал шаарддаг, удаан хугацаанд хэрэгждэг зэрэг олон бэрхшээл ногоон хөрөнгө оруулалт, ногоон санхүүжилтийг нэмэгдүүлэхэд тулгарч байна.

Хүснэгт 2. Ногоон зээлийн зах зээлд тулгардаг бэрхшээлүүд

Хөрөнгө оруулалтын орчинд нийтлэг тулгардаг бэрхшээл	<ul style="list-style-type: none"> Эдийн засгийн бэрхшээл: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой бодлогын хэрэгжилт сул, зохицуулалтын орчны тогтвортой бус байдлаас шалтгаалан ногоон хөрөнгө оруулалтын өгөөж бага байх магадлал ихтэй; Санхүүгийн бэрхшээл: Ногоон төслүүдийг хэрэгжүүлэхэд эхлэлтийн хөрөнгө оруулалт их шаарддагаас гадна төсөлд шаардагдах капиталын зардал өндөр байдаг нь хөрөнгө оруулалтын эрсдэлийг нэмэгдүүлдэг; Хууль, эрх зүйн бэрхшээл: Санхүүгийн салбар дахь зохицуулалтын орчны хангалтгүй байдлаас шалтгаалан ногоон зээлийн бүтээгдэхүүний нийлүүлэлт багасах үр нөлөөтэй;
Эрэлт талын бэрхшээл	<ul style="list-style-type: none"> Ногоон зээл, ногоон санхүүжилтийн талаар олон нийтийн ойлголт бага байна; Бизнесийн ихэнх загварууд урт хугацааны өсөлтөөс илүү богино хугацааны ашиг, орлогод илүү анхаарал хандуулдаг нь ногоон төсөлд хөрөнгө оруулалт татахад хүндрэлтэй нөхцөл байдал үүсгэж байна; Ногоон төслийг хэрэгжүүлэх байгууллагын дотоод нөөц бололцоо нь сул, хангалтгүй байх тохиолдол их байна;
Нийлүүлэлт талын бэрхшээл	<ul style="list-style-type: none"> Ногоон төсөл, хөтөлбөр нь ихэвчлэн урт хугацаат хөрөнгө оруулалт шаарддаг; Ногоон зээл олгох ногоон санхүүжилт гаргахтай холбоотой санхүүгийн байгууллагуудын боловсон хүчний чадавх сул байна; Ногоон зээл, хөрөнгө оруулалтын төслүүдийн эрсдэлийг зөв үнэлэх, эрсдэлийн удирдлагыг сайн гүйцэтгэх туршлага санхүүгийн байгууллагуудад бага байна; Ногоон зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд шинээр нийлүүлэх нь зардал өндөртэй байна.

Тийм ч учраас зарим улс орнуудын засгийн газар ногоон хөрөнгө оруулалтын сан байгуулах замаар эсхүл төрийн өмчит санхүүгийн байгууллагуудаараа дамжуулан сэргээгдэх эрчим хүч, ногоон тээвэрлэлт, байгаль орчны хог хаягдлыг бууруулахад чиглэсэн төсөл хөтөлбөрийг дэмжиж уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэн, ногоон санхүүжилтийг амжилттай нэвтрүүлж байна. Ер нь хүн бүрийн амьдралын чанар, сайн сайхан байдалд ихээхэн нөлөөтэй байгаль орчны асуудлыг бодлого гаргагчид анхааралдаа аван эдийн засгаа ногооруулах, ногоон санхүүжилтийг нэмэгдүүлэх бодлогыг баримтлан ажиллах зайлшгүй шаардлагатай юм.

Зураг 5. Ногоон зээлийг зах зээлд нэвтрүүлэх загвар /уг загвар нь сүүлийн үед улс орнуудад түгээмэл ашиглагдаж байна/



Эх сурвалж: IACE Institute for Climate Economics

Мөн байгаль орчинд ээлтэй, ногоон зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд амжилттай нэвтрүүлэхэд зах зээлийн тогтвортой байдал,

санхүүгийн байгууллагуудын оролцоо, бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хүргэх суваг, түүний чадавх зэрэг зайлшгүй чухал юм.

Зах зээлийн тогтвортой байдал: Улс орны зах зээл, хөрөнгө оруулалтын орчин таатай бус байвал байгаль, орчны ногоон төслүүдэд бүү хэл ердийн төслүүдэд хөрөнгө оруулалт татах хүндрэлтэй болно. Тийм учраас ногоон санхүүжилтийн таатай орчинг бий болгохын тулд эхлээд зах зээл, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсээ тогтвортой байлгаж хөрөнгө оруулалт татах шаардлагатай юм. Мөн байгаль орчны асуудалд анхаарал хандуулдаг, байгалийн баялгийн доройтол, орчны бохирдолтой тэмцдэг зохицуулалтын орчин ногоон санхүүжилтийг амжилттай нэвтрүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Санхүүгийн зах зээлийн оролцоо: Ногоон санхүүжилтийг нэвтрүүлэхэд мэдээж санхүүгийн байгууллагуудын оролцоо хамгаас чухал. Ногоон зээлийн бүтээгдэхүүн нь ердийн зээлийн бүтээгдэхүүнтэй харьцуулахад илүү төвөгтэй зээл олгох процедуртайгаас гадна, зээлийн нөхцөл нь ялгаатай байх тохиолдол элбэг байдаг. Тийм учраас уг зах зээлд санхүүгийн байгууллага амжилттай оролцоход зах зээлд эзлэх байр суурь, байгууллагын хөрвөх чадвар, зээл олгох нөхцөл, зээлийн бодлого болон байгаль орчин, нийгмийн

хариуцлагын хүрээнд баримталдаг бодлого зэрэг олон хүчин зүйлс нөлөөлдөг. Мөн санхүүгийн байгууллагууд нь ногоон зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нийлүүлэхийн тулд олон улсын байгууллагууд болон бусад мэргэжлийн байгууллагуудаас техникийн туслалцаа, сургалт, зөвлөгөө авах тохиолдол их байна.

Бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэх суваг: Санхүүгийн байгууллагууд ногоон зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлэхэд тэдний бүтээгдэхүүнээ зах зээлд хүргэх суваг чухал нөлөөтэй. Ногоон зээлийн бүтээгдэхүүн нь тухайн зах зээлийн нөхцөл байдалд тохирсон, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн байх шаардлагатай юм. Хэдийгээр байгаль орчинд чиглэсэн санхүүгийн бүтээгдэхүүн нь богино хугацаандаа ямар нэгэн бодит ашгийг хүргэхгүй байж болох ч үүний урт хугацааны үр өгөөжийг заавал бодож үзэх хэрэгтэй. Мөн ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэхэд санхүүгийн байгууллагын хүний нөөц болон хөрөнгийн чадавх сайн байх шаардлага үүсэх бөгөөд энэ төрлийн зээлийн үнэлгээ нь илүү төвөгтэй байдаг учраас хүний нөөцөө сургах, санхүүгийн тайлан болон мэдээллийн системдээ өөрчлөлт оруулах шаардлагатай юм.

Зураг 6. Ногоон зээлийн зах зээлийг хөгжүүлэхэд нөлөөлдөг гол хүчин зүйлс



Зах зээлийн тогтвортой байдал

- Хөрөнгө оруулалтын орчин нөхцөл
- Байгаль орчинд чиглэсэн бодлого, зохицуулалт
- Санхүүжилтийн эх үүсвэр
- Идэвхтэй донор байгууллага, түүний дэмжлэг

Санхүүгийн зах зээлийн оролцоо

- Санхүүжилтийн эх үүсвэр
- Зах зээлд эзлэх байр суурь
- Бизнесийн хөгжил
- Техникийн зөвлөгөө, тусламж
- Санхүүгийн болон үйл ажиллагааны чадавх

Бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх суваг

- Боловсон хүчний болон бусад нөөц
- Боловсон хүчний чадавх
- Бүтээгдэхүүний загвар, сурталчилгаа
- Үр ашиг бүхий мэдээллийн урсгал
- Найдвартай хөрөнгийн үнэлгээ, ил тод тайлагнал

Түүнчлэн сүүлийн жилүүдэд бичил санхүүгийн салбар ногоон зээлийн бүтээгдэхүүнийг санал болгох, үйл ажиллагаандаа байгаль орчинд ээлтэй зарчмыг нэвтрүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар зах зээлд бусад санхүүгийн байгууллагуудыг уриалах, зээлийн шалгууртаа байгаль орчны үнэлгээг оруулах зэрэг байдлаар ногоон санхүүжилтийг нэвтрүүлж буй жишээ олон улсад их байна. Үүний нэг жишээ нь Бангладешийн Грамен Шаки бичил санхүүгийн байгууллага

юм. Уг байгууллага нь бичил зээлээр дамжуулан Бангладешийн олон зуун мянган хөдөөгийн ард иргэдийг нарны эрчим хүчээр хангасан. Мөн Гватемал улсын Генесис бичил санхүүгийн байгууллага нь какао болон кофены ферм эрхэлдэг 4000 өрхөд хөнгөлөлттэй нөхцөлөөр бичил зээл олгон тэдний фермийн үйл ажиллагааг байгаль орчинд ээлтэй байдлаар явуулах нөхцөлийг бүрдүүлж өгсөн байна.

ТАНИЛЦУУЛГА

ЖАЙКА–ААС ХОРООТОЙ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ “ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ” ТӨСЛИЙН I ШАТ

Япон улсын ЖАЙКА байгууллагын техник туслалцааны хүрээнд 2014 оны 12 дугаар сарын 02–ны өдрөөс “Хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх” гурван жилийн хугацаатай төсөл хэрэгжиж эхэлсэн. Уг төслийн зорилго нь Монголын хөрөнгийн зах зээлд үнэт цаасыг олон нийтэд санал болгох, давхар бүртгүүлэх бүртгэлийн орчныг зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх замаар сайжруулах явдал байсан бөгөөд тус зорилгод хүрэхийн тулд зорилтот бүлгийн хяналт, зохицуулалтын чадавхыг сайжруулах, хөрөнгийн зах зээлд оролцогчдын мэдлэгийг дээшлүүлэх замаар хөрөнгийн зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилтуудыг тавьж ажилласан байна.

Төслийг “Хөрөнгийн зах зээлийг бэхжүүлэх бодлогын зөвлөлийг байгуулах”, “Санхүүгийн зохицуулах хорооны хяналт, зохицуулалтын чадавхыг бэхжүүлэх”, “Өөрийгөө зохицуулах



байгууллагын үзэл баримтлалын баримт бичиг/судалгааг боловсруулах”, “Өндөр чадамж бүхий Монголын компаниуд хувьцаагаа олон нийтэд санал болгож давхар бүртгэлд хамруулах”, “Олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх” гэсэн 5 чиглэлээр дотоод болон гадаад /Япон улсад/ сургалт, семинарыг зохион байгуулах, холбогдох ажилтантай зөвлөлдөх хэлбэрээр хэрэгжүүлсэн.

Төслийн эхний шатны хүрээнд төслийн баг Санхүүгийн зохицуулах хорооны үйл

ажиллагаа, хөрөнгийн зах зээлийн хууль, дүрэм журамтай танилцан зах зээлийн судалгаа, зөвлөмжийг боловсруулан, “Эрсдэлд суурилсан хяналт шалгалт”, “Хөрөнгийн зах зээлийн шинэчлэл”, “Хувьцааг олон нийтэд санал болгох”, “Давхар бүртгэл” зэрэг сэдвүүдээр зах зээлд оролцогчдод зориулсан сургалтыг зохион байгуулсан. Мөн Хорооны албан хаагчдыг чадавхжуулах хүрээнд богино хугацааны сургалтанд хамруулсан байна.

ЖАЙКА–ААС ХОРООТОЙ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ “ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ” ТӨСЛИЙН II ҮЕ ШАТ

Санхүүгийн зохицуулах хороо “Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх II үе шатны төсөл”–ийг Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)–тай хамтран хэрэгжүүлэхээр тохиролцож, 2018 оны 10 дугаар сард протоколд гарын үсэг зурж, тус төслийн 2–р үе шатыг 2019 оны 3 дугаар сараас хэрэгжүүлж эхэлсэн.

Тус төсөл нь компанийн бондын зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр холбогдох судалгаа хийх, бодлогын зөвлөгөө боловсруулах, зэрэглэл тогтоох байгууллагын тогтолцоог судлах, биржийн бус арилжааны эрх зүйн зохицуулалт, тогтолцооны зарчмыг тодорхойлох зэрэг ажлуудыг хамарсан болно.

2019 оны 3 дугаар сарын 11–ны өдөр ЖАЙКА байгууллагын Төрийн бодлого санхүүгийн салбарын хэлтсийн орлогч дарга Огата Эрина болон “JCR Eurasia rating” байгууллагын

дэд дарга, доктор Рафи Карагол нар зэрэглэл тогтоох байгууллагын хууль эрз зүйн орчны талаар Санхүүгийн зохицуулах хорооны ҮЦГ–ын дарга Б.Лхагвасүрэн болон холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулсан. Уулзалтын үеэр зэрэглэл тогтоох үйлчилгээг бүрэн нэвтрүүлэх чиглэлд судалгаа хийх, Хорооноос баталсан холбогдох журмуудыг сайжруулж, боловсронгуй болгох, түүнчлэн Үнэт цаасны зах зээлийн тухай хуулинд олон улсын жишигт нийцсэн зарим зүйл заалтыг оруулж өгөх шаардлагатай байгаа талаар Үнэт цаасны газрын дарга Б.Лхагвасүрэн саналаа илэрхийлсэн.

Төслийн багийн зүгээс 2019 оны 3 дугаар сарын 11–ээс 15–ны өдрүүдэд санхүүгийн зэрэглэл тогтоох байгууллага бий болгох хэрэгцээ шаардлагын талаар Монголбанк, Сангийн яам, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудтай уулзалт хийсэн.

ЖАЙКА–ийн ахлах зөвлөх Цүнода Жиро, олон улсын зөвлөх Норитака Акамацү нар “Засгийн газрын бонд болон компанийн

бондын зах зээл” сэдвийн хүрээнд холбогдох сургалтыг 2019 оны 3 дугаар сарын 28–ны өдөр зохион байгуулсан.

Санхүүгийн зохицуулах хороо, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага болох ЖАЙКА–тай хамтран зээлжих зэрэглэл тогтоох байгууллагын хууль эрх зүйн орчин, үйл ажиллагааны практик асуудал сэдвээр 2019 оны 6 дугаар сарын 13–ны өдөр сургалт зохион байгуулж, тус сургалтанд төрийн байгууллагууд, хувийн хэвшлийн болон үнэт цаасны зах зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын төлөөллүүд хамрагдсан.

2019 оны 6 дугаар сарын 14–ний өдөр ЖАЙКА байгууллагын Төрийн бодлого санхүүгийн салбарын хэлтсийн орлогч дарга Огата Эрина зэрэглэл тогтоох байгууллагатай холбоотой зохион байгуулагдсан сургалтын үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар ҮЦГ–ын дарга Б.Лхагвасүрэнтэй уулзалт хийсэн. ЖАЙКА–ийн зүгээс 2019 оны 9 дүгээр сард зэрэглэл тогтоох байгууллагын үнэлгээтэй холбоотой ээлжит сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж байна.

ЯРИЛЦЛАГА



Сэтгүүлийн энэ удаагийн дугаараар бид Дэлхийн банкны бүлгийн Олон улсын санхүүгийн корпорацийн (ОУСК) Монгол Улс дахь төлөөлөгчийн газрын санхүүгийн салбарын ахлах мэргэжилтэн, төслийн удирдагч Б.Батмөнхтэй “Тогтвортой санхүүжилт”-ийн талаар ярилцлаа.

Сайн байна уу? Танд энэ өдрийн мэндийг хүргэе.

Танд ч бас энэ өдрийн мэндийг хүргэе.

Сүүлийн жилүүдэд тогтвортой хөгжил мөн тогтвортой санхүү, ногоон зээл, санхүүжилт гэж их яригдах боллоо. Тэгэхээр ярилцлагаа Тогтвортой хөгжил гэсэн ойлголтыг тодруулахаас эхлэвэл ямар вэ?

Тэгье тэгье. Ер нь тогтвортой санхүүжилтийн талаар ярихаас өмнө тогтвортой хөгжлийн ойлголтын талаар дурдахгүй өнгөрөх аргагүй юм. Тогтвортой хөгжил гэдгийг энгийнээр тайлбарлавал хүн төрөлхтөн, улс орнууд, цаашдаа эдийн засгийн хөгжлийн хурд, өсөлтийг одоо байгаа түвшинд нь хадгалан, эдийн засгаа хөгжүүлэхдээ байгаль дэлхийд аль болох хор хөнөөл учруулахгүй, байгалийн нөөцийг зөв зохистой ашиглан үйл ажиллагаа явуулах тухай ойлголт юм. Зөвхөн ингэж байж л бид бүхэн цаашдаа урт хугацаанд эдийн засгийн хөгжлөө тогтвортой түвшинд авч явах боломжтой байна гэсэн ойлголт дээр үндэслээд дэлхийн улс орнууд тогтвортой хөгжил гэж ярих болсон. Товчхондоо хүн төрөлхтөн цаашдаа эдийн засгаа хөгжүүлэн авч явахдаа байгалийн хомс хязгаарлагдмал нөөцийг зөв зохистой ашиглаж, байгаль дэлхийд хор хөнөөл учруулахгүй харилцан шүтэлцээтэй, эдийн засаг, байгаль орчин, нийгмийн хөгжлийн харьцааг тэнцвэртэй хадгалан хөгжих ёстой юм байна гэсэн үзэл санааг тогтвортой хөгжил гэж хэлээд байгаа юм.

Санхүүгийн салбар тэгвэл тогтвортой хөгжилтэй яаж холбогдох вэ? Тогтвортой санхүүжилт гэж юу вэ?

Анх 20 дугаар зууны дунд үеэр зарим

томоохон төрийн бус байгууллагууд байгаль дэлхийд хор хөнөөлтэй үйл ажиллагаа явуулж буй компаниудад анхаарлаа хандуулж эхэлсэн байдаг. Жишээ нь: газрын тос олборлодог компани байгаль орчныг сүйтгэх, тэнгис далайд хаягдлаа хаях зэргээр хор хохиролтой үйл ажиллагаа явуулж байлаа гэж бодъё. Ямар ч компани үйл ажиллагаагаа явуулахын тулд санхүүгийн эх үүсвэртэй байх хэрэгтэй. Тэр зээл санхүүжилтийг нь олгож байгаа санхүүгийн байгууллагууд тодорхой хэмжээгээр хариуцлага хүлээх ёстой гэсэн байдлаар ТББ-ууд дуу хоолойгоо хүргэж эхэлсэн байдаг.

Түүнээс хойш 90-ээд оноос эхлэн тогтвортой хөгжлийн үзэл баримтлал буюу дэлхийн улс орнууд байгаль дэлхийтэйгээ харилцан шүтэлцээтэй хөгжих ёстой гэж яригдаж эхэлсэн. 2000-аад оноос тогтвортой хөгжлийн зорилтууд бий болж үүний хажуугаар дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох, сөрөг нөлөөллийг бууруулахад улс орнууд анхаарч эхэлсэн байдаг. Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй сөрөг нөлөөг дэлхийн бүх улс орнууд мэдэрч эхэлсэн. Иймээс дэлхийн улс орнууд тогтвортой хөгжлийн үзэл баримтлалуудыг баримталж, ер нь цаашдаа байгаль дэлхийд үзүүлж байгаа нөлөөллөө анхаардаг болъё, сөрөг нөлөөллийг бууруулж, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицож, гарч байгаа сөрөг үр дагавруудыг бууруулах чиглэлээр ажиллах хэрэгтэй юм байна гэдэг дээр санал нэгдсэний үндсэн дээр ажиллаж эхэлсэн байдаг.

Аливаа бизнесийн үйл ажиллагааг явуулахын тулд санхүүжилт хэрэгтэй байдаг. Санхүүжилтийг ихэвчлэн санхүүгийн

байгууллагууд өгч байдаг. Энэ утгаараа санхүүгийн байгууллагууд энэ асуудал дээр тодорхой хэмжээний хариуцлага хүлээх ёстой болж байна. Нөгөө талаар санхүүгийн байгууллагууд энэ асуудлыг анхаардаг болсноор өөрсдийгөө эрсдэлээс хамгаалах боломжтой болж байгаа юм. Жишээ нь А гэдэг банк зээл олголоо гэж бодъё. Зээл авсан компани нь газрын тос олборлодог бөгөөд байгаль орчинд нөлөөлөх нөлөөгөө тооцоогүй, сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээ аваагүй эсвэл нөхөн сэргээх үйл ажиллагаа хийгээгүйгээс болж тухайн орон нутгийн байгаль, орчинд мөн оршин суугаа хүмүүсийн аж амьдралд нь сөрөг нөлөө үзүүлж эхэлнэ. Ингэснээр хүмүүс эсэргүүцэж төр засгийн байгууллагууд болон холбогдох мэргэжлийн байгууллагууд нь компанийн үйл ажиллагааг зогсоох ч боломжтой. Эцэст нь байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөг урьдчилан тооцоолж, эрсдэлийг бууруулах арга хэмжээ аваагүйгээс болж тэр компани эрсдэлд орж байгаа юм. Цаашлаад тухайн компанийн бизнесийн үйл ажиллагаа нь зогсвол зээл олгосон санхүүгийн байгууллагын зээл эрсдэлд орох аюултай болох юм. Тэгэхээр санхүүгийн байгууллагууд зээл олгохдоо заавал байгаль орчин, нийгэмд ямар нэг сөрөг нөлөө үзүүлж болзошгүйг судлах, үнэлгээ хийх, хэрэв ноцтой сөрөг нөлөө үзүүлэхээр байвал зээл, санхүүжилт олгохоос татгалзах хэрэгтэй болж байна. Энэ нь тогтвортой санхүүжилтийн үндсэн гол ойлголтуудын нэг юм. Өөрөөр хэлбэл, энэ нь санхүүгийн байгууллагуудын компанийн нийгмийн хариуцлагатай холбоотой асуудал ерөөсөө биш бөгөөд харин ч банк санхүүгийн байгууллагуудын ашигт ажиллагаа, зээлийн эрсдэлтэй холбоотой, эрсдэлийн удирдлагын нэг гол хэсэг болох ёстой үйл ажиллагаа юм.

Ногоон санхүүжилт болон тогтвортой санхүүжилт гээд яригддаг. Энэ 2 ойлголт өөр ойлголт уу эсвэл нэг утгатай юу?

Ногоон санхүүжилт гэдэг нь байгаль орчинд ээлтэй төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх үйл ажиллагаа юм. Тогтвортой санхүүжилт гэдэг маань ногоон санхүүжилтийг багтаасан илүү том өргөн хүрээтэй ойлголт байдаг. ОУСК-ийн зүгээс тогтвортой санхүүжилтийг тодорхойлохдоо дараах 2 үндсэн ойлголтуудыг агуулдаг гэж үздэг. Үүнд: Нэгдүгээрт, санхүүгийн байгууллагуудын зүгээс зээл олгохдоо байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээг заавал хийж, болзошгүй эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа. Хоёрдугаарт, санхүүгийн байгууллагууд байгаль орчинд ээлтэй төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл, тогтвортой санхүүжилт гэдэг нь юуны өмнө байгаль орчин нийгмийн эрсдэлийн үнэлгээ хийн сөрөг нөлөөг бууруулах үйл ажиллагаа мөн ногоон зээл, санхүүжилт олгох үйл ажиллагааг хэлж байгаа хэрэг юм.

Монгол Улсад тогтвортой санхүүжилт ямар шатанд байгаа вэ?

Бид анх 2013 онд Монгол улсад Монголын банкны холбоо (МБХ), Худалдаа хөгжлийн банк, Нидерландын хөгжлийн банк болон бусад гол оролцогч байгууллагуудтай

хамтраад “Монголын тогтвортой санхүүжилт” санаачилгыг эхлүүлсэн. Гол санаа нь банк, санхүүгийн байгууллагууд зээл олгохдоо тухайн зээлдэгч, компанийн хэрэгжүүлэх гэж байгаа төсөл, бизнесийн үйл ажиллагаа нь байгаль орчин, нийгэмд ямар нэг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эсэхийг зээл олгохоос өмнө сайн судлаж үнэлэх, тухайн болзошгүй эрсдэлийг бууруулах чиглэлээр арга хэмжээ аван ажиллах тухай юм. Энэ санааг дэмжин 2013 оны 11 дүгээр сард бүх арилжааны банкуудын удирдлагууд тойрч сууж байгаад энэхүү санаачлагад нэгдэн орж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллана гэж амлалт өгөн гарын үсэг зурцгаасан.

Сайн дурын үндсэн дээр хэрэгжиж буй, арилжааны бүх банкууд нэгдэн орсон энэхүү санаачилгыг 2013 оноос хойш Монголын банкны холбоо амжилттай авч явж хэрэгжүүлж эхэлсэн. 2014 онд Монголын тогтвортой санхүүжилтийн 8 зарчмуудыг банкууд өөрсдөө боловсруулан баталж зээл олгох, мөн өөрсдийн өдөр тутмын ажиллагаанд мөрдөнө гэж санал нэгдсэн байдаг. Эдгээр 8 зарчмуудын зарим нэгээс дурдвал, жишээлбэл: зээл олгох үйл ажиллагаандаа байгаль орчин, нийгмийн эрсдэлийг заавал тооцдог болох тухай зарчим байна. Мөн байгаль орчинд ээлтэй ногоон төсөл хөтөлбөрүүдийг дэмжин ажиллах тухай зарчим мөн байдаг.

гол оролцогч байгууллагуудтай хамтраад энэ бүх үйл ажиллагаа, эрсдэлийн үнэлгээг банкууд яаж үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, юунд анхаарах ёстой вэ гэдэг талаар маш их сургалт, сурталчилгааны ажлуудыг хийж байгаа. Өнөөдрийн байдлаар Монголд үйл ажиллагаа явуулж байгаа бүх арилжааны банкууд эдгээр зарчмуудыг сайн дурын үндсэн дээр мөрдөн ажиллаж байгаа ба зарим банкууд энэ асуудлыг хариуцах тусгай баг, орон тоо гарган ажиллуулж байна. Ер нь бол 2013 оноос хойш Монгол улсын банкны салбарт тогтвортой санхүүжилт сайн дурын үндсэн дээр амжилттай хэрэгжсэн гэж бодож байна.

Олон улс, дэлхийн бусад улс орнуудад ч гэсэн тогтвортой санхүүжилтийн үзэл санаа эрчимтэй дэлгэрч хөгжиж байна. Өмнө нь жишээлбэл, 2000-аад оны эхээр тогтвортой санхүүжилт, санхүүгийн байгууллагуудын үүрэг оролцооны талаар ярихад банк санхүүгийн байгууллагууд яагаад үүнийг санхүүгийн байгууллагууд анхаарах ёстой юм бэ, ямар ашиг тустай вэ, гарах зардлыг нь хэн даах вэ гэсэн байдлаар ханддаг байсан бол өнөөдөр тогтвортой санхүүжилт, ногоон зээл гэж ярихад банк санхүүгийн байгууллагуудаас үзүүлж байгаа хариу үйлдэл шал өөр болсон. Өөрөөр хэлбэл, банк санхүүгийн байгууллагууд тогтвортой санхүүжилтийн үзэл санаа зарчмуудыг богино хугацаанд яаж зардал багатайгаар нэвтрүүлэх вэ, олон улсын сайн туршлагуудыг хаанаас харж, суралцаж болох вэ гэдэг байдлаар ханддаг болжээ. Энэ нь юуг харуулж байна гэхээр дэлхий нийт, санхүүгийн салбар тогтвортой санхүүжилт, ногоон зээл, ногоон санхүүжилтийн тогтолцоог бий болгох, эрчимтэй хөгжүүлэх чиглэл рүү явж байгааг харуулж байна. Монгол улс ч гэсэн энэ чиг хандлагаас хоцрохгүйг хичээн ажиллаж байна.

Бусад улс орнуудтай харьцуулахад Монгол Улсын тогтвортой санхүүжилт ямар түвшинд байгаа вэ?

Монгол улсын өнгөрсөн 5 жилийн хугацаанд явуулсан ажлыг олон улсын хэмжээнд маш эерэг байдлаар дүгнэсэн байдаг. Тогтвортой санхүүжилтийн төслийг ОУСК-аас Монгол улсаас гадна өөр бусад олон улс орнуудад хэрэгжүүлж байна. Тогтвортой санхүүжилтийн бодлого журмыг боловсруулах, хөгжүүлэх чиглэлээр ажиллах хүсэлтэй улс орнууд нэгдэж “Олон улсын тогтвортой санхүүжилтийн холбоо”-г 2012 онд анх байгуулсан байдаг. Анх байгуулагдахдаа



Тог-ийн 8 зарчим



Монголын арилжааны банкуудын зээлийн багцад томоохон байр суурь эзэлдэг эдийн засгийн 4 гол салбарууд байдаг нь уул уурхай, хөдөө аж ахуй, барилга, аж үйлдвэрийн салбарууд юм. Эдгээр салбаруудад 50 сая

төгрөгөөс дээш, 12 сараас дээш хугацаатай бизнесийн зээл олгож байгаа банкууд байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээг хийдэг байхаар заасан. Үүнээс гадна төслийн хүрээнд манай байгууллага, МБХ болон бусад

10 гишүүн оронтой болсон байсан бол өнөөдөр уг холбоонд 36 орон гишүүнээр элсэн үйл ажиллагаа явуулж байна. 2018 онд холбооны зүгээс олон улсын нэр хүндтэй аудитын байгууллага болох Эрнст энд Янг (Ernst & Young)–аар гишүүн орнуудын тогтвортой санхүүжилтийн зарчмуудын хэрэгжилтэнд үнэлгээ хийлгэсэн. 35 орныг хамруулан үнэлгээг хийж таван ангиллаар жагсааж үзэхэд тогтвортой санхүүжилтийн зарчмуудыг хамгийн сайн хэрэгжүүлж буй найман орны нэгээр Монгол улс шалгарсан. Энэхүү үнэлгээний талаар Олон улсын тогтвортой санхүүжилтийн хэрэгжилтийн тайлангаас харж болно. Монгол улсад сайн дураар хэрэгжүүлж байгаа тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрийг сайнаар үнэлсэн хэдий ч цаашдаа ямар үйл ажиллагаа хэрэгжүүлэх, юун дээр анхаарах хэрэгтэй байгааг мөн дурдсан байгаа.

Түүнчлэн, холбогдох зохицуулагч байгууллагуудын зүгээс тогтвортой санхүүжилтийн зарчмуудын хэрэгжилтийг сайжруулахад анхааран тодорхой арга хэмжээ аван ажиллаж байна. Жишээлбэл, Монгол банкны зүгээс 2019 оны Мөнгөний бодлогын үндсэн чиглэлд тогтвортой санхүүжилттэй холбоотой үйл ажиллагааны гурван арга хэмжээг хэрэгжүүлэхээр оруулсан байдаг. Нэгдүгээрт, санхүүгийн салбарт байгаль орчинд ээлтэй ногоон зээлийн ангилал шалгуурыг боловсруулахаар болсон. Хоёрдугаарт, байгаль орчин нийгмийн эрсдэлийн үнэлгээг банкууд зээлийн

эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх хяналт шалгалтын заавар зөвлөмж, журам боловсруулж ажиллан, мөрдүүлэх чиглэлээр Монголбанк ажиллана. Гуравдугаарт Монголбанкны зүгээс Монголын санхүүгийн салбарт тогтвортой санхүүжилт төслийн хүрээнд хэрэгжиж буй ногоон зээл, байгаль орчинд ээлтэй төсөл хөтөлбөрүүдийг бүртгэж, тайлагнадаг болох, мэдээллийн бааз бүрдүүлэх зэрэг болно.

Монгол Улсын тогтвортой санхүүжилтийн замын зургийн талаар товч танилцуулж өгнө үү.

Цаашдаа тогтвортой санхүүжилтийн зарчмуудын хэрэгжилтийг сайжруулж, ногоон эдийн засгийн хөгжилд санхүүгийн байгууллагуудын оруулах хувь нэмрийг улам нэмэгдүүлэхийн тулд Монголын тогтвортой санхүүжилтийн замын зураг гэсэн баримт бичгийг боловсруулан гаргасан ба 2018 оны 12 сард санхүүгийн салбарын гол оролцогч талууд уг баримт бичгийг хэрэгжүүлэхээр тохиролцсон билээ. Тогтвортой санхүүжилтийн замын зураг нь Монгол улсад уур амьсгал, байгаль орчин, нийгэм, засаглалын хүчин зүйлүүдийг анхаарсан тогтвортой санхүүжилтийн шаардлагуудыг санхүүжилт, хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаа, бодлого, тогтолцоонд нэвтрүүлэх мөн байгаль орчин ээлтэй ногоон хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө юм. Энэхүү баримт бичиг мөн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гол оролцогч

байгууллагууд ямар үүрэг оролцоотой оролцох, ямар дэмжлэг үзүүлж ажиллах зэргийг тодорхой зааж өгсөн байдаг. Мөн замын зургийг амжилттай хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, тогтвортой санхүүжилтийн зарчмуудыг эдийн засгийн бусад салбаруудад нэвтрүүлэх ажлыг манлайлах зорилгоор Монголын тогтвортой санхүүжилтийн холбоо гэсэн шинэ ТББ байгуулагдан ажиллаж байна.

Нөгөө талаар цаашид тогтвортой санхүүжилтийн зарчим, шаардлагуудыг зөвхөн арилжааны банкууд бус бусад зээл, санхүүжилт олгодог санхүүгийн байгууллагууд мөн адил дагаж мөрдөх хэрэгтэй болж байна. Ингэснээр арилжааны банкуудаас гадна бусад санхүүгийн байгууллагууд өөрсдийгөө байгаль орчин нийгэмтэй холбоотой болзошгүй эрсдэлээс хамгаалах боломжтой болох юм. Мөн бүх санхүүгийн байгууллагууд маань нэг ижил дүрмийн дагуу, адилхан шаардлага тавьж ажилладаг болно. Энэ утгаараа бид СЗХ–той хамтран ББСБ–д чиглэсэн тогтвортой санхүүжилтийн зарчмуудыг үйл ажиллагаанд нь нэвтрүүлэн, дагаж мөрдөх аргачлалыг боловсруулах чиглэлээр ажиллаж байгаа.

Уншигчид маань тогтвортой санхүүжилтийн ойлголтыг хангалттай авсан гэж бодож байна. Цаг заваа гарган ярилцсан танд баярлалаа.

Танай хамт олонд ч баярлалаа. Ажлын амжилт хүсье.

ӨРГӨН ДУРАН – СУРВАЛЖЛАГА

ХҮРТЭЭМЖТЭЙ НОГООН САНХҮҮЖИЛТИЙН 4Р ХҮРЭЭ

/Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх бодлогын хариу арга хэмжээ/

2018 оны сүүлээр Францын гудамжинд хэдэн зуун мянган “шар хантаазтангууд” нүүрсхүчлийн хийн ялгарлыг бууруулах зорилготой шатахууны татварын өсөлтийг эсэргүүцэж жагсав. Хэдийгээр зарим хүмүүс энэ өсөлтийг цаг уурын өөрчлөлттэй тэмцэх улс орнуудад ухаалаг алхам болно гэж үзсэн ч, жагсагчид Францын орлого багатай хүн амд хамгийн хүндээр тусна гэж мэдэгджээ. Жагсаал өнөөдрийг хүртэл үргэлжилсээр байгаа бөгөөд цаг уурын үйл ажиллагааны бодлого нь бага орлоготой бүлгүүдийн эрх ашгийг үл тоомсорлож болохгүйг сануулсаар байна.



АFI–гийн гишүүн улс орнуудын ихэнх нь цаг уурын өөрчлөлтөд маш эмзэг байдаг. Үүнээс үүдэн, АFI–ийн гишүүн байгууллагууд цаг уурын өөрчлөлтийн нөлөөнөөс хамгаалах, тэсвэрлэх чадварыг сайжруулах зорилгоор бага орлоготой бүлгүүд болон бичил, жижиг дунд үйлдвэрүүдэд чиглэсэн тэднийг хөгжүүлэх бодлого баримталж байгаа бөгөөд Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгээс гишүүн орнуудаас ногоон санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээг хангамж, идэвхжүүлэлт, хамгаалалт, урьдчилан сэргийлэлт гэсэн бүрэлдэхүүнээс бүрдэх “Хүртээмжтэй ногоон санхүүжилтийн 4Р хүрээ”–г боловсруулсан байна. Бүрэлдэхүүн тус бүрийг улс орнуудад хэрэгжүүлж буй арга хэмжээ, жишээтэйгээр доор үзүүлээ.

- **Хангамж/Provision/:** Хангамжийн бодлого нь төр өөрөө болон засгийн газраас үүрэг болгосны дагуу хувийн хэвшлийн шалгуур хангасан оролцогчдын үзүүлж буй санхүүгийн үйлчилгээ нь иргэдэд үр ашигтайгаар хүргэхэд тусалдаг. Тухайлбал, Бангладешийн төв банк, Непалийн төв банк, Фижийн Нөөцийн

банк ногоон санхүүжилтийн зээлийн баталгаажсан квотыг нэвтрүүлээд байна. Пакистаны Төрийн банк ногоон зээл олгох зорилгоор дахин санхүүжилтийн арга хэрэгслийг боловсруулсан бол Вануатугийн Нөөцийн банк нь 2015 онд халуун орны Далайн шуурганд өртсөн аж ахуйн нэгжүүдийг сэргээн босгох зорилгоор дахин санхүүжилтийн арга хэрэгслийг бий болгосон байна.

Идэвхжүүлэлт /Promotion/: Идэвхжүүлэлтийн бодлого нь хувийн хэвшлийнхэн зорилтот хэрэглэгчдэд санхүүгийн үйлчилгээ үзүүлэхэд нь урамшуулал олгох боломжийг бүрдүүлдэг. Тухайлбал, Филиппиний Төв банк арилжааны банкуудыг ногоон зээлд хамрагдах бизнесийн загварыг нэвтрүүлэхэд үйл явцад идэвхжүүлэн, ёс зүйн талаас нь ойлголт өгсөн. Филиппиний Төв банк нь ногоон зээлийн талаарх ойлголтын зөрүүг арилгах, мөн нэн түрүүнд боловсон хүчинг чадавхжуулах арга хэмжээнд анхааран ажиллаж байсан. Харин Бангладешийн төв банк нь ногоон санхүүжилтийн үйл ажиллагааныхаа тайланг улирал тутам авч, мэдээлэл үүсгэн, түгээх үйл ажиллагааг өрнүүлж байна. Мэдээлэл цуглуулах, түгээх нь гүйцэтгэлийг хэмжих үзүүлэлтийг бий болгох чухал арга хэрэгсэл юм. Эцэст нь Вануатугийн нөөцийн банк арилжааны банкуудын нөөц сангийн шаардлагыг багасган бодлогын хүүг бууруулснаар банкуудыг далайн шуургад өртсөн бага орлоготой хүмүүст зээл олгоход нөлөөлжээ.

Хамгаалалт /Protection/: Хамгаалах бодлого нь даатгал эсвэл нийгмийн даатгалын нөхөн төлбөрөөр дамжуулан болзошгүй алдагдлыг “нийтийн болгох” эсвэл хувийн өмчид онцгой боломж олгох замаар санхүүгийн эрсдэлийг бууруулдаг. Жишээлбэл, Нигерийн Төв банк хиймэл дагуулын тусламжтайгаар гаргасан хур тунадасны мэдээллийг ашиглан боломжит тариалангийн ургацын гарцын таамаглалд үндэслэн тариаланчдад автоматаар нөхөн төлбөр өгдөг орлогын индексийн даатгалыг бий болгосон. Нигерийн Төв банк нь жижиг фермерүүд зээлээ төлж чадахгүй бол зээлийн алдагдлын 50 хүртэлх хувийг зээлдүүлэгчид нөхөн олгодог. Фижи улсын Засгийн газар нь хар салхинд хохирсон хүмүүст “Өрхүүдэд туслах” санаачилга гарган гар утсаар засгийн газраас хүмүүст G2P төлбөр

олгож байсан байна. Вануатугийн засгийн газар далайн шуурганы улмаас орон гэргүй болж хохирсон хүмүүст орон гэрээ шинээр босгоход тэтгэврийн данснаасаа 20 хүртэлх хувийг урьдчилан авч ашиглах боломжийг олгожээ.

Урьдчилан сэргийлэлт /Prevention/: Урьдчилан сэргийлэх бодлого нь хохирол учирсны дараа шийдвэрлэхээс илүүтэйгээр учирч болзошгүй хохирлоос зайлсхийх зорилготой юм. Жишээлбэл, Бангладешийн төв банк, Бразилийн төв банк, Пакистан улсын Төрийн банк, Непалийн төв банк, Парагвайн төв банк зэрэг AFI-ийн гишүүн байгууллагууд нийгмийн болон хүрээлэн буй орчны гадаад байдал, санхүүгийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг үнэлэх, шийдвэрлэхэд чиглэсэн Байгаль орчны (ба нийгмийн) эрсдэлийн менежментийн удирдамжийг

хэрэгжүүлсэн. Санхүүжилтийг санамсаргүй үр дагавар, хоёрдогч үр нөлөө, бүтээгдэхүүнээр задлан анхаарлаа хандуулахыг шаардсанаар байгаль орчны (ба нийгмийн) эрсдэлийн бодлого нь илүү цогц санхүүгийн орчинг бүрдүүлээд зогсохгүй санхүү, нийгэм, байгаль орчны эрсдэлийг бууруулдаг давуу талтай юм.

AFI-ийн гишүүд өргөн хүрээний бодлого хэрэгжүүлсэн хэдий ч бид цаг уурын өөрчлөлтийн асуудал дээр үүрэг нь улам нэмэгдэж буй төв банкуудын ажлын дөнгөж эхлэлийг ярьж байна. Санхүүгийн үйлчилгээ нь бага орлоготой хүмүүст зайлшгүй шаардлагатай боловч санхүүгийн зохицуулагч нар Үндэсний зохицуулах хөтөлбөр зэрэг цаг уурын стратеги боловсруулахад системтэй оролцоогүй байна. Хүртээмжтэй ногоон санхүү нь бодлогын хүрээнд хөгжихийн хэрээр AFI нь шинээр гарч ирж буй бодлогын практикийг үргэлжлүүлэн хөгжүүлсээр байна.



PROVISION. Засгийн газар өөрөө болон түүний үүрэг болгосны дагуу хувийн хэвшлийн шалгуур хангасан оролцогчдын үзүүлж буй санхүүгийн үйлчилгээ нь иргэдэд үр ашигтайгаар хүргэхэд тусалдаг.



PROMOTION. Идэвхжүүлэлтийн бодлого нь хувийн хэвшлийнхэн зорилтот хэрэглэгчдэд санхүүгийн үйлчилгээ үзүүлэхэд нь урамшуулал олгох боломжийг бүрдүүлдэг.



PREVENTION. Урьдчилан сэргийлэх бодлого нь хохирол учирсны дараа шийдвэрлэхээс илүүтэйгээр учирч болзошгүй хохирлоос зайлсхийх зорилготой юм



PROTECTION. Даатгал эсвэл нийгмийн даатгалын нөхөн төлбөрөөр дамжуулан болзошгүй алдагдлыг “нийтийн болгох” эсвэл хувийн өмчид онцгой боломж олгох замаар санхүүгийн эрсдэлийг бууруулдаг.



Эх сурвалж: Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг

ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Зохицуулалттай этгээд: Тайлант хугацаанд 53 компани Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд үнэт цаасны арилжаа эрхлэх 2, үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх 1, төвлөрсөн хадгаламжийн 1, кастодиан банкны үйлчилгээ үзүүлэх 3, хөрөнгө оруулалтын менежментийн 20 компани үйл ажиллагаа явуулж байгаа бол хөдөө аж ахуйн биржийн арилжаа, зуучлалын чиглэлээр арилжаа эрхлэх 1, бараа, түүхий эдийн арилжааны зуучлалын үйл ажиллагаа эрхлэх 13 этгээд байна.

Арилжааны гүйлгээ:

Монголын Хөрөнгийн Бирж (МХБ): 2019 оны 2 дугаар улиралд хувьцааны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 376.9 сая ширхэг хувьцааг 82.3 тэрбум төгрөгөөр, ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 79.8 мянган ширхэг үнэт цаасыг 7.9 тэрбум


төгрөгөөр тус тус арилжиж, нийт 90.2 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийсэн байна.

Монголын Үнэт Цаасны Бирж (МҮЦБ): Тайлант улиралд МҮЦБ-ийн хоёрдогч зах зээлийн арилжаагаар 9,000 ширхэг компанийн өрийн хэрэгслийг 90.0 сая төгрөгөөр, 5.1 сая ширхэг хувьцааг 228.9 сая төгрөгөөр тус тус арилжаалав.

МХБ болон МҮЦБ-ээр өссөн дүнгээр нийтдээ 90.5 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 4.6 тэрбум төгрөгөөр өсчээ.

Зах зээлийн үнэлгээ болон хөрвөх чадвар: 2019 оны 2 дугаар улирлын байдлаар үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 2,604.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 119.9 тэрбум төгрөг буюу 4.8 хувиар өссөн үзүүлэлт юм. Тайлант үед нийт 82.5 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдэж хөрвөх чадвар 3.2 хувь болов. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.2 пунктээр өссөн үзүүлэлт юм.


Зураг 11: Зах зээлийн үнэлгээ ба хөрвөх чадвар



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ЗЗҮ/ДНБ-ий харьцаа: Тайлант улиралд ЗЗҮ-г 2018 оны жилийн эцсийн үйлдвэрлэлийн аргаар тооцсон нэрлэсэн ДНБ-ний хэмжээтэй харьцуулахад 8.1 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.4 пунктээр өссөн үзүүлэлт юм.

Зураг 12: Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх зах зээлийн үнэлгээний хувь



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хувьцааны индекс: Олон улсад хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдлыг тайлбарладаг бас нэгэн үзүүлэлт нь хувьцааны индекс байдаг. Тухайлбал, Нью-Йоркийн хөрөнгийн бирж болон Насдакийн хөрөнгийн бирж дээр арилжаалагддаг томоохон 500 компанийн зах зээлийн үнэлгээнд суурилан тооцдог Стандарт энд Пүүрс 500 (Standard and Poor's 500 буюу S&P 500) индекс нь Америкийн хөрөнгийн зах зээлийн голлох үзүүлэлтүүдийн нэг юм. Манай орны хувьд “Монголын хөрөнгийн бирж” ХК-аас хоёр төрлийн индекс тооцдог. Хамгийн өндөр үнэлгээтэй 20 компанийн зах зээлийн үнэлгээнд суурилан тооцдог ТОП-20 индекс, үнэт цаасны бүртгэлийн I ба II ангилалд багтах компанийн зах зээлийн үнэлгээнд суурилсан MSE A болон MSE B индексүүдийг тооцож байна.

ТОП-20: Тайлант үед ТОП-20 индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 823.8 нэгжээр буюу 4.1 хувиар өсч 20,785.21 нэгж болсон бөгөөд индексийн дээд үзүүлэлт 21,888.16 нэгж, доод үзүүлэлт 19,566.58 нэгж, дундаж үзүүлэлт 20,655.13 нэгж байна.

MSE A болон MSE B: Тайлант хугацаанд MSE A индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 80.87 нэгжээр буюу 0.8 хувиар буурч 9,743.03 нэгж болсон бөгөөд индексийн дээд үзүүлэлт нь 10,268.72 нэгж, доод үзүүлэлт нь 8,711.07 нэгж, дундаж үзүүлэлт нь 9,509.62 нэгж байна.


MSE B индексийн хувьд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,517.15 нэгжээр буюу 15.7 хувиар буурч 8,116.71 нэгж болсон бөгөөд индексийн дээд үзүүлэлт нь 8,860.92 нэгж, доод үзүүлэлт нь 7,702.09 нэгж, дундаж үзүүлэлт нь 8,234.16 нэгж байна.

ХАА-Н ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Хөдөө аж ахуйн бирж нь анх 2013 оны 4 дүгээр сарын 05-ны өдрөөс хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд арилжаалж эхэлсэн ба үүнээс хойш 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 3.1 их наяд төгрөгийн арилжаа явуулжээ.

ХАА-н биржийн арилжаа: ХАА-н биржээр дамжин 2019 оны 2 дугаар улирлын байдлаар өссөн дүнгээр нийт 523.0 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 79.6 тэрбум төгрөг буюу 17.9 хувиар өссөн үзүүлэлт юм.

Зураг 13: Хөдөө аж ахуйн биржийн арилжаа /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ХАА-н биржийн индекс: Хөдөө аж ахуйн бирж 2015 оноос биржийн индекс тооцоолж олон нийтэд мэдээлж эхэлсэн. MAPIX нь бирж дээр арилжаалагдаж байгаа бараа түүхий эдийн үнийг тусгай загвараар жигнэж тооцоолсон үнэ юм. Биржийн индекс нь сонгосон бүлэг бараа эсвэл салбар дахь барааны үнийг ерөнхий багцаар харах боломж олгодог. Тайлант улиралд MAPIX индекс хамгийн ихдээ 1,085,809.5 нэгж хүрсэн.

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Даатгалын зах зээлийн бүтэц: Даатгалын зах зээлд өнөөгийн байдлаар ердийн даатгалын 15 компани, урт хугацааны даатгалын 1 компани, давхар даатгалын 2 компани үйл ажиллагаа явуулж байна. Харин мэргэжлийн оролцогчдын хувьд 52 даатгалын зуучлагч компани байгаагаас давхар даатгалын зуучлагч 7, мөн даатгалын зуучлалын үйлчилгээ үзүүлэгч 9 банк байна. Даатгалын хохирол үнэлэгч 26 компани, 2493 даатгалын төлөөлөгчид тус тус СЗХ-ноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж байна.


Даатгалын гүнзгийрэлтийн түвшин: Даатгалын салбарын үндсэн үзүүлэлтүүд сүүлийн жилүүдэд өсөлттэй байгаа хэдий ч салбарын хөгжлийн гол хэмжүүр болох даатгалын гүнзгийрэлт буюу ДНБ-д эзлэх хураамжийн орлогын хувь хэмжээ олон улстай харьцуулахад

доогуур байна. 2019 оны хоёрдугаар улирлын байдлаар даатгалын гүнзгийрэлт 0.64 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.08 пунктээр өссөн үзүүлэлт юм.

Олон улсын хандлагаас харахад урт хугацааны даатгалын гүнзгийрэлт ердийн даатгалаас илүү өндөр хувьтай байдаг бол манай орны хувьд нөхцөл байдал эсрэгээрээ байна. Европын болон Азийн зарим орнуудад урт хугацааны даатгалын гүнзгийрэлт 5 хувиас дээш, Өмнөд Африк болон Хятадад 10 хувиас дээш байхад манай орны хувьд сүүлийн жилүүдэд дунджаар 0.01 хувьтай байгаа юм.

Голлох үзүүлэлтүүд: Даатгалын зах зээлийн хэмжээг илэрхийлэх гол үзүүлэлтүүдийн нэг болох нийт хөрөнгийн хэмжээ даатгалын салбарын хувьд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 25.7 хувиар өсөж 354.7 тэрбум төгрөгт хүрсэн. Даатгалын салбарт давхар даатгалын нэг компани нэмэгдсэнтэй холбоотойгоор даатгалын салбарын хөрөнгийн бүтцэд өөрчлөлт гарсан ба давхар даатгалын нийт хөрөнгийн салбарын үзүүлэлтэд эзлэх хувь хэмжээ өнгөрсөн оны мөн үед 16.6 хувь байсан бол тайлант улирлын байдлаар 20.7 хувь болж өслөө. Салбарын нийт хөрөнгийн 76.7 хувийг ердийн даатгалын компаниудын хөрөнгө, 2.6 хувийг урт хугацааны даатгалын компанийн хөрөнгө тус тус эзэлж байна.

Зураг 14. Даатгалын салбарын нийт хөрөнгө, нөөц сан /тэрбум төгрөгөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Харин нийт хураамжийн орлого өмнөх оны хоёрдугаар улирлаас 23.7 хувиар өсөж 104 тэрбум төгрөг болов. Энэхүү өсөлтийн 99 хувийг ердийн даатгалын компаниудын нийт хураамжийн орлогын өсөлт бүрдүүлэв. Хураамжийн орлогын төвлөрүүлэлтийг авч үзвэл даатгалын зуучлагчид 19.7 тэрбум төгрөг буюу 18.9 хувийг, даатгалын төлөөлөгчид 22.1 тэрбум төгрөг буюу 21.2 хувийг бүрдүүлсэн байна.

Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал тайлант улиралд 25.7 тэрбум төгрөгт хүрч, нийт хураамжийн орлогын 24.8 хувийг эзлэв. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нөхөн төлбөрийн зардал 11.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Үүнээс ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөр 99 хувийг бүрдүүлж байна.

Зураг 15. Даатгалын салбарын нийт хураамжийн орлого, нөхөн төлбөр /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын компаниуд өөрийн хүлээж авсан эрсдэлээ шилжүүлэх зорилгоор давхар даатгалын компанид даатгуулдаг. Манай орны хувьд дийлэнх даатгалын компаниуд гадны давхар даатгалын компанид эрсдэлээ даатгадаг ба тайлант онд даатгалын компаниуд нийт 33.7 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийн зардалтай ажилласан нь өмнөх оны мөн үеэс 42.2 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд нийт хураамжийн орлоготой харьцуулахад 32.4 хувь байна.

Салбарын өөрийн хөрөнгийн өгөөж 7.3 хувь, нийт хөрөнгийн өгөөж 3.7 хувь байна.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Банк бус санхүүгийн байгууллагуудын статистик үзүүлэлтүүд: 2019 оны 2 дугаар улирлын байдлаар санхүүгийн зах зээл дээр нийт 538 банк бус санхүүгийн байгууллага Хорооны олгосон тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж байна. Тайлант улиралд банк бус санхүүгийн байгууллагуудын тоо өмнөх оны мөн үеэс 0.19 хувиар буурсан байна. Үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо багассан хэдий ч банк бус санхүүгийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэж байна. Тайлант улиралд банк бус санхүүгийн байгууллагын харилцагчдын


тоо 2.3 сая болж өмнөх оны мөн үеэс 64.9 хувиар, нийт зээлдэгчдийн тоо 360.3 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 2.4 дахин өслөө.

Салбарын хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй 538 банк бус санхүүгийн байгууллагын 13.9 хувь нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа бол 86.1 хувь нь нийслэл Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байна. Мөн нийт байгууллагуудын 5.0 хувь нь гадаадын хөрөнгө оруулалтаар санхүүжиж байгаа бол 95.0 хувь нь дотоодын хөрөнгө оруулалттай байгууллагууд байна.

Банк бус санхүүгийн байгууллагуудын хөрөнгө: Тайлант улиралд банк бус санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгийн хэмжээ 1.5 их наяд төгрөгт хүрэн өмнөх оны мөн үеэс 389.4 тэрбум төгрөгөөр буюу 34.0 хувиар өсжээ. Активын бүтцээс харвал энэхүү өсөлтийн 84.3 хувийг нийт зээлийн өсөлт дангаараа бүрдүүлж байна. Харин пассивын бүтцээс харвал хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 184.4 тэрбум төгрөгөөр буюу 26.1 хувиар өсөн 892.2 тэрбум төгрөгт хүрсэн нь хөрөнгийн өсөлтийн 47.4 хувийг бүрдүүлж байна.

2019 оны 2 дугаар улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудын нийт өөрийн хөрөнгийн 1.2 их наяд төгрөгт хүрсэн ба энэ нь өмнөх оны мөн үеэс 30.0 хувиар өссөн үзүүлэлт юм.

Зураг 16: Нийт хөрөнгө ба өөрийн хөрөнгө /тэрбум төгрөгөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Банк бус санхүүгийн байгууллагуудын зээл: 2019 оны 2 дугаар улиралд банк бус санхүүгийн салбарт нийт 861.3 тэрбум төгрөгийн зээл олгогдож, 630.9 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, салбарын нийт зээлийн үлдэгдэл улирлын эцэст 1.1 их наяд төгрөг байна. Сүүлийн жилүүдэд банк бус санхүүгийн байгууллагуудын зах зээлд нийлүүлж буй зээлийн бүтээгдэхүүний хэмжээ тасралтгүй өсөж байгаа ба 2019 оны 2 дугаар улирлын салбарын нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 42.7 хувиар буюу 328.4 тэрбум төгрөгөөр

өссөн дүнтэй байна. Зээлийн нийлүүлэлтийн энэхүү өсөлтөд байгууллагуудын хөрөнгийн чадавх сайжирсан, эх үүсвэрийн хэмжээ нэмэгдсэн, мөн зээлийн бүтээгдэхүүний хүртээмж сайжирсан нь голчлон нөлөөлсөн.

Тайлант улирлын зээлийн үлдэгдлийн 97.0 хувийг төгрөгөөр, 3.0 хувийг валютаар олгосон зээл бүрдүүлж байгаа бөгөөд, нийт зээлийн үлдэгдлийн 84.7 хувийг иргэнд, 15.3 хувийг хуулийн этгээдэд олгосон зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.


Зураг 17: Нийт зээлийн өсөлт




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт олгосон зээлийн 87.2 хувь нь хэвийн, 3.9 хувь нь хугацаа хэтэрсэн зээл ба 8.9 хувь нь чанаргүй зээл байна. Чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлийн үлдэгдэлд эзлэх хувиуд нь өмнөх оны мөн үеэс харгалзан 0.6 болон 1.6 пунктээр тус тус буурсан байна.

Зураг 18: Зээлийн төрөл, валютаар



Зураг 19: Зээлийн төрөл, чанараар




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зээлийн зориулалтаар авч үзвэл нийт олгосон зээлийн 71.7 хувийг хэрэглээнд, 12.7 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 6.4 хувь нь барилгын салбарт, 2.6 хувь нь байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйлчилгээний салбарт, 2.4 хувь нь уул уурхай, олборлолтын салбарт олгогдсон байна. Нийт эргэн төлөгдсөн зээлийн

хувьд авч үзвэл 70.9 хувь нь хэрэглээнээс, 14.7 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбараас, 6.4 хувь нь барилгын салбараас, 3.1 хувь нь уул уурхай, олборлолтын салбараас, 1.6 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбараас, 1.4 хувь нь байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйлчилгээний салбараас эргэн төлөгдсөн байна.

Зураг 20: Олгосон зээл, төлөгдсөн зээл, зориулалтаар




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн жигнэсэн дундаж сарын хүү тайлант улиралд 3.3 хувь болж өмнөх оны мөн үеэс өөрчлөгдөөгүй байна. Харин 2016 болон 2017 оны мөн үеүдтэй харьцуулахад харгалзан 0.7 болон 0.2 пунктээр тус тус бага байна.

Зээлийн хүүгийн бууралтад эдийн засгийн нөхцөл байдал сайжирсан нь нөлөөлсөн байж болох ч банк бус санхүүгийн салбарт зээлийн бүтээгдэхүүний нийлүүлэлт нэмэгдсэн нь үнийн түвшин болох хүүгийн түвшинг буурахад нөлөөлсөн байх боломжтой юм.

Зураг 21: Зээлийн хүү




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

ХЗХ-дын тоо болон гишүүд: 2019 оны хоёрдугаар улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж буй хадгаламж, зээлийн хоршоодын тоо 275-д хүрч өмнөх оны мөн үеэс 4.8 хувиар буурлаа. Хоршоодын ажиллагсдын тоо өнгөрсөн оны мөн үеэс 3.4 хувиар нэмэгдсэн ба

нийт ажиллагсдын 73.4 хувийг эмэгтэй ажилчид эзэлж байна. Хадгаламж, зээлийн хоршоодын нийт гишүүдийн тоо өнгөрсөн оны мөн үеэс 10.4 хувиар буюу 6,347-ээр өсөж тайлант улиралд 67,524-д хүрсэн байна.


Зураг 22: ХЗХ-дын тоо болон гишүүдийн тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ХЗХ–дын хөрөнгө: Тайлант улиралд хоршоод нийт 210.6 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй ажилласан бөгөөд өмнөх оны мөн үеэс 19.6 хувийн өсөлтийг үзүүлж өнгөрсөн оны өсөлтөөс 16.4 пунктээр буурав.

Зураг 23. Нийт хөрөнгө, түүний өсөлт




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ХЗХ–дын хадгаламж: Тайлант улиралд нийт хадгаламж 148.4 тэрбум төгрөг буюу өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 19.2 хувиар өссөн. Нийт ХЗХ–дын 90.5 хувь буюу 249 ХЗХ нь нийт 148.4 тэрбум төгрөгийн хадгаламж төвлөрүүлсэн бол үлдсэн 9.5 хувь буюу 26 ХЗХ

нь огт хадгаламж татаагүй байна. Нийт хадгаламжийн 97.6 хувь нь хугацаатай хадгаламж бусад 2.4 хувь нь хугацаагүй хадгаламж эзэлж байна.

Зураг 24. Нийт хадгаламж, түүний өсөлт



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Мөн хадгаламж, зээлийн хоршоодын нэг гишүүнд ногдох хадгаламжийн хэмжээ нь хангайн бүсэд хамгийн ихдээ 2.6 сая төгрөг, дунджаар 0.7 сая төгрөг байгаа ба зүүн бүсэд нэг хүнд ногдох хамгийн их хадгаламжийн хэмжээ 1.7 сая төгрөг, бүсийн дунджаар 0.9 сая төгрөг байна. Баруун бүсэд нэг хүнд ногдох хамгийн их хадгаламжийн хэмжээ 2.2 сая төгрөг, бүсийн дунджаар 0.4 сая төгрөгийн бага дүнтэй байгаа нь зарим хоршоо огт хадгаламж татаагүй байгаатай холбож болно. Харин төвийн бүсийн хувьд нэг хүнд ногдох хамгийн их хадгаламжийн хэмжээ бусад бүстэй харьцуулахад бага буюу 0.9 сая төгрөг, бүсийн дунджаар 0.4 сая төгрөг байна.

Тайлант улирлын байдлаар, хадгаламж, зээлийн хоршоодын хувь нийлүүлсэн хөрөнгө өнгөрсөн жилийн мөн үеэс 19.7 хувь буюу 2.9 тэрбум төгрөгөөр өсөж 17.5 тэрбум төгрөгт хүрсэн байна. Харин хоршоологчдын өмч өнгөрсөн жилийн мөн үеэс 34 хувиар буюу 4.7 тэрбум төгрөгөөр өсөж 18.6 тэрбум төгрөгт хүрсэн ба түүний бүрдэл болох нөөцийн сан 21.8 хувь, хуримтлагдсан орлого 51.1 хувийг эзэлж байна. Хадгаламж, зээлийн хоршоодын нийт орлого, зарлага мөн адил өндөр өсөлттэй байгаа бөгөөд илүү дэлгэрэнгүйг ашигт ажиллагаа бүлгээс харах боломжтой.

Хүснэгт 5. ХЗХ–дын актив ба пассивын ерөнхий үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2018.И	2019.И	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Нийт хөрөнгө	176.1	210.6	34.5	19.6%
Нийт зээл	134.1	156.5	22.4	16.7%
Хэвийн зээл	121.7	145.3	23.5	19.3%
Хугацаа хэтэрсэн зээл	4.1	4.9	0.8	18.5%
Чанаргүй зээл	8.3	6.4	(1.9)	-22.5%
Хэвийн бус зээл	3.7	1.8	(1.9)	-51.5%
Эргэлзээтэй зээл	3.2	1.2	(1.9)	-61.4%
Муу зээл	1.4	3.4	2.0	145.5%
Хадгаламж	124.5	148.4	23.9	19.2%
Хугацаагүй	3.7	3.6	(0.1)	-3.5%
Хугацаатай	120.7	144.7	24.0	19.9%
Хувь нийлүүлсэн хөрөнгө	14.6	17.5	2.9	19.7%
Хоршоологчдын өмч	13.9	18.6	4.7	34.0%
Нийт орлого	19.3	24.4	5.1	26.3%
Нийт зарлага	18.2	21.5	3.3	18.1%
Нийт ашиг	1.1	2.9	1.8	161.9%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2019 ОНД БОЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

9 ДҮГЭЭР САРЫН 5–20

“Дотоод хяналтыг сайжруулах нь” семинар /Төв, хангайн бүсийн ХЗХ–д/

10 ДУГААР САРЫН 17

Олон улсын хадгаламж, зээлийн хоршооны өдөр /MOCCU expro/

9 ДУГААР САРЫН 9–13

СХН–ийн ээлжит Дэлхийн бодлогын форум, Руандагийн Бүгд Найрамдах Улс

10 ДУГААР САРЫН 31

Дэлхийн хуримтлалын өдөр

11 ДҮГЭЭР САР

17th annual conference of the International Association of Insurance Supervisors /IAIS/ , Abu Dhabi 2019

9 ДҮГЭЭР САРЫН 26–29

Азийн ХЗХ–дын холбооны форум, Малайз улс

11 ДҮГЭЭР САР 02

“Хөгжлийн төлөө хамтдаа” чуулган



Монгол Улс, Улаанбаатар хот 15160
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3
Засгийн газрын IV байр.



+976-51-264444



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



Санхүүгийн зохицуулах хороо